ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ ГАЗАР НУТГИЙН ТУХАЙ ХУУЛИЙН НИЙЦЭЛ, ҮР НӨЛӨӨ, ГАЗАР ОЛГОЛТ” ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ ГАЗАР НУТАГТ ЗӨВШӨӨРӨЛГҮЙ, ХУГАЦААГАА СУНГУУЛААГҮЙ ГАЗАР АШИГЛАХ ЗӨРЧИЛ ЦӨӨНГҮЙ БАЙНА.

АУДИТЫН КОД: АДГ-2022/24-ШТА-ГА

Дарга, Тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар

Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn

Аудитын менежер Б.Тэгшдэлгэр

Утас: 99089114 Цахим хаяг: tegshdelgerb@audit.gov.mn

Ахлах аудитор Д.Отгонбаяр

Утас:89306788 Цахим хаяг: otgonbayarde@audit.gov.mn

Аудитор Н.Гүрбазар

Утас: 99979050 Цахим хаяг: gurbazarn@audit.gov.mn

Аудитор З.Даваадорж

Утас: 89100230 Цахим хаяг: davaadorjz@audit.gov.mn

Хөвсгөл аймаг

2022 он

Энэхүү тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу. Цахим хуудас: www.khuvsgul.audit.mn

АГУУЛГА

Тайланг бэлтгэсэн:

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газар

Тэргүүлэх аудитор
А.Эрдэнэбаатар
Аудитын менежер
Б.Тэгшдэлгэр
Ахлах аудитор
Д.Отгонбаяр
Аудитор
Н.Гүрбазар
З.Даваадорж

Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл гарвал 70384043 дугаарын утас, 70383793 дугаарын факсаар харилцана уу.

ХАЯГ: Мөрөн сум Аймгийн ЗДТГ-ын “А” корпус 3 давхар

Цахим хаяг:
audit.mn/?page_id=579

2022 оны 12 дугаар сар

Товчилсон үгийн жагсаалт

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

Ерөнхий мэдээлэл

***БҮЛЭГ 1.* Хуулийн шаардлага хангасан газар нутгийг улсын тусгай хамгаалалтад авсан байна.**

1.1 Тусгай хамгаалалттай газар нутгаас олсон Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогыг эргэн хуваарилж хөрөнгө оруулалт хийхгүй байна.

1.1.1 Хуулийн шаардлага хангасан газар нутгийг улсын тусгай хамгаалалтад авсан байна.

1.1.2 Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуульд заасан эрх хэмжээний хүрээнд УИХ-аас улсын тусгай хамгаалалтад авах шийдвэрийг гарган хилийн заагийн өөрчлөлтийг тухай бүр шинэчлэн баталсан байна.

1.1.3 Хамгаалалтын захиргааны орон тоо хүрэлцээ муутай байна.

1.1.4 Тусгай хамгаалалттай газар нутгийг хамгаалах ажлыг санхүүжүүлэх хөрөнгийн эх үүсвэрийг орон нутгийн төсөвт хуваарилж, батлаагүй байна.

1.2 Хөвсгөлийн улсын тусгай хамгаалалттай газарт 68 иргэн, аж ахуйн нэгж газар ашиглах зөвшөөрөлгүйгээр жуулчны бааз, гэр буудлын зориулалтаар ашиглаж байна.

1.2.1. Хамгаалалтын захиргаа нь тусгай хамгаалалттай газар нутгийн зөвшөөрөгдсөн бүсэд ашиглуулах газрын хэмжээ, байршлыг менежментийн төлөвлөгөөнд тусгаагүй байна.

1.2.2. Ойн менежментийн төлөвлөгөө гаргаж ажиллаагүй байна.

***БҮЛЭГ 2.* Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль болон Байгаль орчныг хамгаалах тухай хуулийг нийцүүлэн өөрчлөх шаардлагатай байна.**

2.1. Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн холбогдох заалт нь Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль, Газрын тухай хууль, Газрын төлбөрийн тухай хуультай нийцэж байна.

2.2. Байгаль орчин аялал жуулчлалын яамнаас газар ашиглуулах шийдвэрийг олгохдоо Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуультай нийцүүлэн гаргахгүй байна.

***БҮЛЭГ 3.* Хамгаалалтын захиргааны тусгай хамгаалалтын газар нутгийг хамгаалах ажил хангалтгүй байна.**

3.1.1. Хамгаалалтын захиргаа нь Тусгай хамгаалалттай газар нутагт ой, хөрс, ургамал, ан амьтан бүхий газар нутгийг хадгалах, хамгаалах ажлыг судалгаа, шинжилгээнд үндэслэж хийгээгүйгээс ажлын үр дүнг тодорхойлох боломжгүй, хуульд заасан чиг үүрэг,

	менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан ажлын биелэлт хангалтгүй байна. 3.1.2. Ковид-19 цар тахлаас шалтгаалан олон улсын туршлагыг судлах, нэвтрүүлэх ажил хийгдээгүй байна. ***БҮЛЭГ 4.* Тусгай хамгаалалттай газар нутагт төрийн бусад байгууллага хяналт хэрэгжүүлээгүй байна.** **Дүгнэлт** **Зөвлөмж** **Зөрчлийн жагсаалт**

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
БНМАУ	Бүгд найрамдах Монгол ард улс
ҮАГ	Үндэсний аудитын газар
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
УИХ	Улсын Их Хурал
МУЗГ	Монгол Улсын Засгийн газар
БОАЖЯ	Байгаль орчин аялал жуулчлалын яам
БОАЖС	Байгаль орчин аялал жуулчлалын сайд
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ЗГТС	Засгийн газрын тусгай сан
ТХГН	Тусгай хамгаалалттай газар нутаг

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОРЫН ТУШААЛ

2022 оны 12 сарын 07 өдөр Дугаар А/23 Мөрөн сум

Аудитын тайланг баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын 18.9, 2018 оны А/207 “Эрх үүрэг шилжүүлэх тухай” дугаар тушаалын 5 дугаар хавсралтын 2.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн нийцэл, үр нөлөө, газар олголт” гүйцэтгэлийн аудитын тайланг нэгдүгээр хавсралтаар, аудитаар өгсөн албан шаардлагуудыг хоёрдугаар хавсралтаар баталсугай.
2. Аудитын тайланг Үндэсний аудитын газрын Гүйцэтгэл-нийцлийн аудитын газар, Хөвсгөлийн улсын тусгай хамгаалалттай газрын Хамгаалалтын захиргаа, Хөвсгөл аймгийн Татварын хэлтэс, Алаг-Эрдэнэ, Ханх, Чандмань-Өндөр, Ренчинлхүмбэ сумдын Засаг дарга нарт тус тус хүргүүлсүгэй.
3. “Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн нийцэл, үр нөлөө, газар олголт” гүйцэтгэлийн аудитын зөвлөмж, албан шаардлагыг хэрэгжүүлэн биелэлтийг 2023 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн дотор Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Хөвсгөлийн улсын тусгай хамгаалалттай газрын Хамгаалалтын захиргааны дарга Г.Энхбаяр, Хөвсгөл аймгийн Татварын хэлтсийн дарга Ч.Хуншагай, Алаг-Эрдэнэ сумын Засаг дарга З.Ням-очир, Ханх сумын Засаг дарга Л.Даваабаяр, Чандмань-Өндөр сумын Засаг дарга Л.Энхжаргал, Ренчинлхүмбэ сумын Засаг дарга Д.Отгонбаяр нарт зөвлөсүгэй.
4. Аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ахлах аудитор /Д.Отгонбаяр/-т үүрэг болгосугай.
5. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын Аудитын менежер /Б.Тэгшдэлгэр/-т даалгасугай.
6. Аудитын ажлын болон нотлох баримтыг 2022 оны 12 дугаар сарын 20-ний өдрийн дотор архивын нэгж болгон архивд хүлээлгэн өгөхийг аудитын баг /ахлах аудитор Д.Отгонбаяр/-т үүрэг болгосугай.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР А.ЭРДЭНЭБААТАР

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын
даргын 2022 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн
A/23 тоот тушаалын хоёрдугаар хавсралт

Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн нийцэл,
үр нөлөө, газар олголт” гүйцэтгэлийн аудитын албан шаардлагын
жагсаалт

д/д	Албан шаардлагын утга	Хариуцах байгууллага	Албан шаардлагын дугаар
1	Зөрчил арилгах тухай	Хөвсгөлийн улсын тусгай хамгаалалттай газрын Хамгаалалтын захиргаа	87/А2270438/АДГ-2022/24-ШТА-ГА
2	Зөрчил арилгах тухай	Алаг-Эрдэнэ сумын Засаг дарга	88/А2270438/АДГ-2022/24-ШТА-ГА

ооОоо

ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ

Хөвсгөлийн улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргаа *нь /цаашид “хамгаалалтын захиргаа” гэх/* Хөвсгөл аймгийн Алаг-Эрдэнэ сумын Хатгал тосгонд үйл ажиллагаагаа явуулж байна.

Хөвсгөл аймгийн “Хөвсгөл нуур” байгалийн цогцолборт, “Даян дээрхийн агуй” байгалийн дурсгалт газрууд нь Хөвсгөлийн улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргааны /цаашид “хамгаалалтын захиргаа” гэх/ хамгаалалтад хамаарч байна.

Хатгал тосгон, Алаг-Эрдэнэ, Чандмань-Өндөр, Цагаан-Үүр, Ханх, Рэнчинлхүмбэ сум зэрэг нийт 6 сум, тосгоны нутаг хамарсан Хөвсгөл нуурыг бүхэлд нь тойрсон 1,545.2 мянган га газар газар нутгийг 40 албан хаагч хариуцан ажиллаж байна.

Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.8[1], 27.9[2] тусгай хамгаалалттай газар нутгийн зөвшөөрөгдсөн бүсэд шинээр байгуулах аялал, жуулчлалын бааз, амралт, сувиллын байршил, аж ахуйн нэгж, байгууллага, иргэнд ашиглуулах газрын дээд хэмжээг тухайн газрын онцлогтой уялдуулан тогтоохоор хууль тогтоомжоор зохицуулсан байна.

Дээрх хуулийн 27.9-д заасны дагуу Байгаль орчны сайдын 2001 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн 218 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар “Монгол Улсын Тусгай хамгаалалттай газар нутаг дэвсгэрт газар ашиглах, зөвшөөрөл олгох түр журам”-ыг баталж 2022 оны 07 дугаар сарын 08-ны өдрийг хүртэл мөрдсөн байна.

Тус түр журамд иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын газар ашиглах тухай өргөдөл, хүсэлт, хэрэгжүүлэх төслийг хянан үзээд Тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан газар ашиглуулах байршилтай нийцсэн бол Төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэхээр заасан байна.

[1] тусгай хамгаалалттай газар нутгийн зөвшөөрөгдсөн бүс дэх суурин газрын ерөнхий төлөвлөгөө, шинээр байгуулах аялал, жуулчлалын бааз, амралт, сувиллын байршил, төслийг холбогдох төрийн захиргааны төв байгууллагуудтай хамтран хянан батлах;

[2] тусгай хамгаалалттай газар нутгийн зөвшөөрөгдсөн бүсэд тодорхой зориулалтаар ашиглаж болох газар, түүний хэмжээ, ашиглах журам, уг газарт байлгаж болох малын төрөл, тоог тогтоох;

БҮЛЭГ 1. БОАЖЯ, ХАМГААЛАЛТЫН ЗАХИРГААНААС ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ ГАЗАР НУТАГТ ЗӨВШӨӨРӨЛГҮЙ ГАЗАР АШИГЛАХ ЗӨРЧЛИЙГ АРИЛГАХ ТАЛААР НЭГДСЭН АРГА ХЭМЖЭЭГ АВЧ АЖИЛЛААГҮЙ БАЙНА.

1.1 Хамгаалалтын захиргааны орон тоо хүрэлцээ муутай байна.

Хуулийн шаардлага хангасан газар нутгийг улсын тусгай хамгаалалтад авсан байна.

Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуульд “*байгалийн унаган төрхөө харьцангуй хадгалсан, түүх, соёл, шинжлэх ухааны болон танин мэдэхүй, экологийн хүмүүжилд ач холбогдол бүхий улсын тусгай хамгаалалтад авсан газар нутгийг*” **байгалийн цогцолборт газар** байна тодорхойлсон.

Хөвсгөл нуур нь дэлхийн арван долоон эртний нуурын нэг бөгөөд 2 сая гаруй жилийн настай, Азийн цэнгэг уст нууруудаас усны эзлэхүүнээрээ хоёрт жагсах бөгөөд Монгол улсын нийт цэнгэг усны 70%-г өөртөө агуулдаг, байгалийн унаган төрхөө хадгалсан, Хөвсгөл нутгийн нэрийн хуудас болсон түүх, соёлын ач холбогдол бүхий газар юм.

Дэлхий нийтээр цэвэр усны хомсдолд орж буй өнөө үед Хөвсгөл нуур болон түүний ойр орчмыг хамгаалалтад авах нь байгаль, стратегийн хувьд чухал ач холбогдолтой юм. Хөвсгөл нуурт 1950-иад оноос хойш шатахуун ачсан 50 гаруй тээврийн хэрэгсэл живсэн бөгөөд үүнээс 17-г нь тухайн үед гаргаж авч байжээ. Ийм учир Хөвсгөл нуурыг улсын тусгай хамгаалалтад авсан нь нэн чухал ач холбогдолтой ажил болсон байна.

Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуульд заасан эрх хэмжээний хүрээнд УИХ-аас улсын тусгай хамгаалалтад авах шийдвэрийг гарган хилийн заагийн өөрчлөлтийг тухай бүр шинэчлэн баталсан байна.

БНМАУ-ын Бага Хурлын 1992 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн 11 дүгээр *“Зарим газар нутгийг улсын тусгай хамгаалалтад авахыг зөвшөөрөх тухай”* тогтоолоор тусгай хамгаалалтад авч УИХ-ын 1995 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн 26 дугаар тогтоолоор Хөвсгөл нуур, түүний сав газар, Цагаан-Үүр-Уйлганы орчмын зарим газар нутгийг хамарсан газрын "Хөвсгөлийн байгалийн цогцолборт " хилийн заагийг тогтоосон байна.

УИХ-ын 2011 оны 05 сарын 05-ны өдрийн 18 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар хилийн заагийг шинэчлэн тогтоож Хөвсгөлийн байгалийн цогцолборт газрын хилийн заагаас Хөвсгөл аймгийн Алаг-Эрдэнэ сумын Хатгал тосгон болон Ханх сумын төвийн эдэлбэр газрыг тус тус чөлөөлсөн байна.

УИХ-ын 2019 оны 05 сарын 02 өдрийн 41 дүгээр тогтоолоор Хөвсгөл аймгийн Цагаан-Уул, Цэцэрлэг, Шинэ-Идэр, Бүрэнтогтох сум, Завхан аймгийн Тэлмэн, Их-Уул сумын нутгийг дамнан орших Тэсийн гол, Булнайн нурууг байгалийн цогцолборт газрын ангиллаар улсын тусгай хамгаалалтад авч “Хөвсгөлийн Улсын тусгай хамгаалалттай газрын Хамгаалалтын захиргаа” хариуцан 2020 оноос хойш ажиллаж байна.

Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.2[3] дахь хэсэгт заасан эрх хэмжээний хүрээнд УИХ-аас улсын тусгай хамгаалалтад авах шийдвэрийг гарган хилийн заагийн өөрчлөлтийг тухай бүр шинэчлэн баталсан байна.

Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.2[4] дахь хэсэгт зааснаар аймаг өөрийн нутаг дэвсгэрт байгаа тодорхой газар нутгийг орон нутгийн тусгай хамгаалалтад авч болохоор зохицуулсан, тус хуулийн 28.3[5]-д заасан эрх хэмжээний хүрээнд аймаг болон сумын ИТХ-аас тодорхой газар нутгийг орон нутгийн хамгаалалтад авах шийдвэр гарган хилийн заагийг тогтоож өгсөн байна.

---

[3] *Засгийн газрын өргөн мэдүүлснээр газар нутгийг тусгай хамгаалалтад авах тухай шийдвэр гаргах, эдгээр газрыг улсын тусгай хамгаалалттай газар нутгийн тодорхой ангилалд хамааруулах, дархан цаазат болон байгалийн цогцолборт газрын хилийн заагийг батлах, өөрчлөх.*

[4] *Аймаг өөрийн нутаг дэвсгэрт байгаа тодорхой газар нутгийг орон нутгийн тусгай хамгаалалтад авч болно.*

[5] *нутаг дэвсгэрийнхээ тодорхой хэсгийг орон нутгийн хамгаалалтад авах тухай шийдвэр гаргах, түүний хилийн заг, хамгаалалтын горимыг тогтоох.*

Хамгаалалтын захиргааны орон тоо хүрэлцээ муутай байна.

Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.4[6], Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль 27 дугаар зүйлд заасны дагуу Байгаль, орчин аялал жуулчлалын сайдын 2018 оны А/09, 2020 оны А/79 дүгээр тушаалаар хамгаалалтын захиргааны бүтэц, орон тоог баталсан байна. *Хүснэгт №1*

д/д	Албан тушаал	2018 он	Албан тушаал	2020 он
1	Хамгаалалтын захиргааны дарга	1	Хамгаалалтын захиргааны дарга	1
2	Судалгаа шинжилгээ, байгалийн нөөц, мэдээллийн сан хариуцсан мэргэжилтэн	1	Ахлах мэргэжилтэн - /**1**/	
3	Аялал жуулчлал, газар зохион байгуулалт хариуцсан мэргэжилтэн	1	Судалгаа шинжилгээ, байгалийн нөөцийн хамгаалалт, мэдээллийн сан хариуцсан мэргэжилтэн	1
4	Хуулийн хэрэгжилт, хяналт шалгалт хариуцсан мэргэжилтэн	1	Газар ашиглалт хариуцсан мэргэжилтэн	1
5	Сургалт, сурталчилгаа, гадаад хамтын ажиллагаа хариуцсан мэргэжилтэн	1	Хуулийн хэрэгжилт, хяналт шалгалт хариуцсан мэргэжилтэн	1
6	Байгаль хамгаалагч	25	Аялал жуулчлал, сургалт, сурталчилгаа, орчны бүс хариуцсан мэргэжилтэн	1
7	Нягтлан бодогч	1	Байгаль хамгаалагч	25
8	Нярав, бичиг хэрэг, архив, дотоод ажил	1	Нягтлан бодогч	1
9	Үйлчлэх ажилтан /жолооч, сахиул галч, үйлчлэгч/	3	Архив, бичиг хэрэг, нярав, дотоод ажил	1
	Нийт	**35**	Үйлчлэх ажилтан /жолооч, сахиул, галч, үйлчлэгч/	3
			Гэрээгээр ажил гүйцэтгэх байгаль хамгаалагч	5
			Нийт	**40**

БОАЖС нь бүтэц, орон тоог 2020 онд батлахдаа гэрээт байгаль хамгаалагч ажиллуулахаар тооцож 5-аар нэмэгдүүлсэн байна.

Бүтэц, орон тоог батлахдаа БОАЖС нь Засгийн газрын 2006 оны 87 дугаар тогтоолыг үндэслэн Хөвсгөлийн улсын тусгай хамгаалалттай газрын бүслүүрийг ойт, хээрийн бүслүүрээр тооцож тогтоосон байна. Засгийн газрын 2006 оны 87 дугаар тогтоолоор ойт хээрийн бүслүүрт нэг байгаль хамгаалагч 50 мянган га газрыг хариуцах ба дараах тохиолдлуудад хариуцах талбайн хэмжээг багасгаж болохоор заасан байна. Үүнд:

- ЮНЕСКО-гийн хүн ба шим мандлын нөөц газрын жагсаалтад бүртгэгдсэн бол 10 мянган га,
- Тусгай хамгаалалттай газарт үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжийн тоо 31-ээс дээш бол 20 хүртэл мянган га,
- Хамгаалалтын газар нутгийн хилийн заагаас 30 хүртэл км-т сумын төв, томоохон суурин газар байдаг бол 8 мянган га хүртэл бууруулж болохоор тогтоосон байна.

[6] /хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хамаарах төрийн байгууллага, албан газрын бүтэц, дүрмийг баталж, дарга /эрхлэгч, захирал/-ыг томилж, чөлөөлнө

Хөвсгөлийн улсын тусгай хамгаалалттай газар, газрын орчим нь байгаль хамгаалагчийн хариуцах талбайн хэмжээг багасгах шалгуурыг бүрэн хангаж байгаа бөгөөд багасган тооцвол хамгаалалттай газрын зарим хэсэгт нэг байгаль хамгаалагч 12 мянган га газар хариуцаж болохоор байна.

Орон тооны хувьд:

Улсын Их Хурлын 1995 оны 26 дугаар тогтоол, 2011 оны 18 дугаар тогтоол, 2019 оны 41 дүгээр тогтоолд зааснаар /Тэсийн гол, Булнайн нурууны тусгай хамгаалалттай газар нутгийг оруулаад/ 1,545.2 мянган га газар Хөвсгөлийн улсын тусгай хамгаалалттай газар нутагт хамаарч байна.

Засгийн газрын 2006 оны 87 дугаар тогтоолд заасан хэмжээгээр авч үзвэл хамгаалалтын захиргааны нэг байгаль хамгаалагчид /гэрээт 5 байгаль хамгаалагчийг оруулаад/ 51.5 мянган га газар ноогдож байна.

Хөвсгөл нуур, нуур орчмын газар нутаг нь аялал жуулчлалын хөдөлгөөн ихтэй, хамгаалалттай газрын газар зүйн онцлогоос шалтгаалан Хөвсгөлийн улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргааны орон тоог нэмэгдүүлэх шаардлагатай байна.

Хамгаалалтын захиргааны орон тоог зайлшгүй нэмэгдүүлэхэд дараах хүчин зүйлс нөлөөлж байна. Үүнд:

1. Хөвсгөл нуур нь аялал жуулчлалын маш идэвхтэй бүс нутаг, тусгай хамгаалалттай газар нутаг дотор буюу нуурын урд болон хойд үзүүрт Ханх сумын төв, Хатгал тосгон байршдаг, нуурын орчим зөвшөөрөлтэй болон зөвшөөрөлгүй 200 гаруй амралтын газар, гэр буудлын үйл ажиллагаа явагддаг, иргэд зуны улиралд нуурын эргийн орчим байрлаж амардаг зэргээс шалтгаалан нуурын эрэг орчим байгаль хамгаалагч нарын хамгаалалтыг нягтруулж байгаа нь үлдсэн нутаг дэвсгэрийн хамгаалалтыг сулруулж байна. Иймд Засгийн газрын 2006 оны 87 дугаар тогтоолоор батлагдсан “Байгаль хамгаалагчийн хариуцах талбайн хэмжээ”-ний 2[7]-т зааснаар нэг байгаль хамгаалагчид ногдох талбайн хэмжээг 5-20 мянган га хүртэл багасгаж ажиллах шаардлага үүссэн.
2. Юнеско-ийн хүн ба шим мандлын нөөц газрын жагсаалтад бүртгэгдсэн тул Хөвсгөл нуур орчмын 1,172.6 мянган га газарт /Тэсийн гол, Булнайн нурууны тусгай хамгаалалттай газар нутгийг хасаж тооцсон/ ажиллаж буй 26 байгаль хамгаалагчийн хариуцах талбайн хэмжээг Засгийн газрын 2006 оны 87 дугаар тогтоолоор батлагдсан “Байгаль хамгаалагчийн хариуцах талбайн хэмжээ”-ний 1[8]-т зааснаар 10 мянган га-гаар багасгаж хамгаалалтыг сайжруулах шаардлага үүссэн.
3. Хамгаалалттай газрын нутаг дэвсгэр салангид байдгаас шалтгаалж зарим хэсэгт байгаль хамгаалагчийн хариуцах газар нутгийн хэмжээнээс илүү газар нутаг хариуцаж байна. Тухайлбал:
   - Тэсийн гол, Булнайн нурууны хамгаалалттай газар нутгийн хэмжээ нь 369.6 мянган га газар бөгөөд 3 байгаль хамгаалагч ажиллаж байна. Энэ газар нутагт нэг байгаль хамгаалагчийн хариуцах талбайн хэмжээ нь 123.2 мянган га газар болж байгаа нь хариуцах талбайн хэмжээнээс 2.5 дахин их байна.
   - Даян дээрхийн байгалийн дурсгалт газрын хамгаалагдах талбайн хэмжээ бага 31 мянган га газар боловч 1 байгаль хамгаалагч ажиллаж байгаа нь байгаль хамгаалагчид тулгарах эрсдэл болон ажил үүргээ гүйцэтгэх боломжгүй /өвдөх гэх мэт/ болсон үед хамгаалалттай газар нутаг хамгаалалтгүй үлдэх эрсдэлийг нэмэгдүүлж байна.

[7] Тухайн газар нутгийн байгалийн нөөц баялгийн ашиглалт, аж ахуйн нэгжийн тоо, үйл ажиллагаанаас хамааран байгаль хамгаалагчийн хариуцах талбайг дор дурдсан хэмжээгээр бууруулж болно:

[8] . Улсын хил дамнасан тусгай хамгаалалттай газар, олон улсын ач холбогдол бүхий ус, намгархаг газар, ялангуяа усны шувууд олноор амьдардаг орчны тухай олон улсын конвенци /Рамсарын конвенци/, ЮНЕСКО-гийн хүн ба шим мандлын нөөц газрын жагсаалт болон дэлхийн байгаль соёлын өвд бүртгэгдсэн газар нутагт энэхүү талбайн хэмжээг 10.0 хүртэл мян.га-гаар бууруулж тооцож болно.

Бүтэц, зохион байгуулалтын хувьд:

Хамгаалалтын захиргаа нь Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 30 дугаар зүйлд зааснаар хамгаалалтын горимыг хангуулах, судалгаа шинжилгээ хийх зөвшөөрөл олгож гэрээ байгуулах, судалгаа шинжилгээний дээж, сорьц авах, ан, амьтны сүргийн бүтцийг зохицуулах, байгалийн баялгийг нөхөн сэргээх, ойн арчилгаа цэвэрлэгээ хийх, ан амьтад амьдрахад дэмжлэг үзүүлэх, рашаан эмчилгээ, сувилгааны зориулалттай эрдэс, байгалийн дагалт баялгийг ашиглуулах, газартай холбоотой менежмент хэрэгжүүлэх, суурин газрыг тохижуулах, баригдаж буй барилга байгууламжид хяналт тавих, ёс заншлын ажиллагааг зохицуулах, сургалт сурталчилгаа явуулах, мэдээллийн сан бүрдүүлэх, зөвшөөрөгдсөн бүсэд байлгаж болох малын төрөл, тоо болон зохих журмын дагуу иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад ашиглуулах газрыг тогтоох зэрэг үндсэн 10 чиг үүргийг хэрэгжүүлж ажиллаж байна.

Эдгээр чиг үүргүүдийг хэрэгжүүлэх бүтцийг БОАЖС-ын 2020 оны А/79 дүгээр тушаалаар баталсан байна. /Дүрслэл № 1-ээр харуулав./

БОАЖС нь Хамгаалалтын захиргааны бүтэц, зохион байгуулалтыг хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлэх боломжтой байдлаар баталсан байна.

Бүтэц, зохион байгуулалт, орон тооноос гадна байгаль хамгаалагчдын үйл ажиллагааны үр дүнд сөргөөр нөлөөлж болохуйц нөхцөл байдлууд үүссэн байна. Үүнд:

1. Хамгаалалтын захиргааны үндсэн 25 байгаль хамгаалагчийн боловсрол, мэргэжил харилцан адилгүй экологи-байгаль хамгааллын мэргэжилтэй – 8, нягтлан бодогч мэргэжилтэй – 3, Аялал жуулчлалын менежмент мэргэжилтэй – 1, ойн ан агнуурын техникч мэргэжилтэй – 1, ойн техникч мэргэжилтэй – 1, хүрээлэн байгаа орчны экологи мэргэжилтэй – 1, мэргэжилгүй, бүрэн дунд боловсролтой – 9 байгаль хамгаалагч байна. Байгаль хамгаалагчдын ажлын байрны тодорхойлолтыг 2013, 2019 онуудад баталж байсан бөгөөд 2013 оны ажлын байрны тодорхойлолтод байгаль хамгаалагч экологич, байгаль хамгаалал, эрх зүйч зэрэг мэргэжлийн, дээд боловсролын шаардлага тавьж байсан боловч 2019 онд шинэчлэн батлагдсан ажлын байрны тодорхойлолтоор мэргэжил, дээд боловсролын шаардлагыг бүрэн дунд боловсрол болон түүнээс дээш гэж өөрчилсөн нь байгаль хамгааллын ажлын үр дүнг бууруулах үйлдэл болсон байна.
   Учир нь Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1-т зааснаар хамгаалалтын захиргааны хамгаалалт хариуцсан ажилтан болон байгаль хамгаалагч нь байгаль орчны хяналтын улсын байцаагчийн эрх, үүрэгтэй байдаг тул

улсын байцаагчийн эрх авах, эрх үүргээ хэрэгжүүлэх мэдлэг дутах зэрэг сөрөг нөлөө үүсэх магадлалтай байна.

2. Байгаль хамгаалагчийн ажил үүргээ гүйцэтгэх, техник хэрэгсэл хангалтгүй байна. Эд хөрөнгийн судалгаагаар 25 байгаль хамгаалагчид албанаас олгосон, байгууллагын эд хөрөнгөд бүртгэлтэй дараах техник, хэрэгсэл ашиглагдаж байна:

Хүснэгт № 2

д/д	Нэг бүрийн тусгай хэрэгслийн нэр	Тоо, хэмжээ /ширхгээр/	Чанар байдал
1	Компьютер	1	Сайн
2	Мотоцикл	10	Дунд
3	Зургийн аппарат	3	Муу
4	Байрлал илрүүлэгч /GPS/	8	Дунд
5	Хийн гар буу	2	Муу
6	Бороохой	1	Муу
7	Шувууны буу	1	Муу
8	Дуран	2	Муу
Нийт дүн		**27**	

Хамгаалалтын захиргааны 25 байгаль хамгаалагчийн дунд цөөн тооны, ашиглах боломжгүй муу техник хэрэгсэл ашиглагдаж байгаа нь байгаль хамгаалах ажлын үр дүнд сөрөг нөлөө үзүүлэх боломжтой байна.

Хамгаалалтын захиргааны байгаль хамгаалагчийн орон тоо хүрэлцээ муутай, боловсрол мэргэжил харилцан адилгүй, техник хэрэгсэл дутмаг зэрэг нь ажлын үр дүнд сөрөг нөлөө үзүүлэх эрсдэлийг дагуулж байна.

Тусгай хамгаалалттай газар нутгийг хамгаалах ажлыг санхүүжүүлэх хөрөнгийн эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс хуваарилж, батлаагүй байна.

Төсвийн эх үүсвэрийн талаар: Тусгай хамгаалалттай газар нутгийг хамгаалах ажлын төсвийг байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг нөхөн сэргээх, газрыг засаж тохижуулах арга хэмжээг хэрэгжүүлэх, судалгаа шинжилгээ хийх, сурталчлах зардал, ажиллагсдын цалин хөлс зэрэгт зарцуулахаар хуульчилсан байна. Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуульд зааснаар ТХГН-ийг хамгаалах ажлыг санхүүжүүлэх эх үүсвэр нь:

- Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт
- Аялал жуулчлалын болон бусад ажил, үйлчилгээний орлого
- Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хандив, тусламж
- Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль тогтоомж зөрчсөн этгээдийн учруулсан хохирлын нөхөн төлбөрийн орлогоос бүрдэж байна.

Хамгаалалтын захиргааны 2019-2022 оны орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийг хүснэгтээр харуулбал дараах байдалтай байна.

Хүснэгт № 3 /сая.төг/

Орлогын нэр төрөл	2019 он		2020 он		2021 он		2022 хагас жил	
	Төл	Гүй	Төл	Гүйц	Төл	Гүйц	Төл	Гүйц
Улсын төсвийн санхүүжилт	336.9	336.9	492.9	481.7	522.4	522.4	304.8	304.8
ТХГН-т түр нэвтрэхэд авах хураамж	25.0	67.3	29.1	24.3	29.1	37.1	29.1	8.7
Нөхөн төлбөр	-	0.7	-	10.1	-	3.7	-	1.0
Гэрээний дагуу газрын төлбөрийн 30%	-	1.3	-	4.3	-	7.3	-	0
Бусад /түрээс/	-		-	18.6	-	0.05	-	
Нийт дүн	**361.9**	**406.2**	**552.0**	**539.0**	**551.5**	**570.5**	**333.9**	**314.5**

Дээрх хүснэгтээс харахад нийт эх үүсвэрийн 90 гаруй хувийг улсын төсвийн санхүүжилтээр бүрдүүлсэн ба орон нутгийн төсвөөс хөрөнгө хуваарилж батлаагүй байна.

БОАЖС-ын 2001 оны 117 дугаар тушаалын 4 дүгээр хавсралтаар Тусгай хамгаалалтай газар нутагт түр нэвтрэн ороход иргэнээс төлөх төлбөрийн хэмжээг гадаадын иргэнээс 3000 төгрөг, Монгол Улсын иргэн тус тарифын 10%-тай тэнцэх хөлсийг төлөхөөр тогтоосон бөгөөд 20 гаруй жилийн өмнө тогтоосон тус тарифыг одоог хүртэл мөрдөж байна.

Гадаад аялагчаас 3000 төгрөг, дотоод аялагч 300 төгрөг төлүүлж байгаа нь хураамжийн хэмжээ хэтэрхий бага, бэлэн бусаар төлбөр тооцоо хийхэд хянах боломжгүй байна. Аялагч, жуулчдын тоотой харьцуулж хүснэгтээр харуулбал:

Хүснэгт № 4 /сая.төгрөг/

Он	Аялагчдын тоо		Нэвтрэх цэгийн хураамжийн орлого	
	Дотоод	Гадаад	Дотоод	Гадаад
2019	59,122	16,482	17.7	49.4
2020	80,591	50	24.1	0.15
2021	58,532	0	37.1	0
2022.09	107.915	18,475	32.4	55.4
	306,160	**35,007**	**111.3**	**105.0**

Аялагчаас авах хураамжийн хэмжээг сүүлийн 20 гаруй жил өөрчлөн тогтоогоогүй байгаагаас одоо авч байгаа хураамж нь тасалбарын хэвлэлтийн зардлаа ч нөхөж чадахгүй хэмжээнд хүрсэн байна. ***Тухайлбал:*** Тасалбар хэвлэлтийн зардал 2022 онд дотоод жуулчинд 300 төгрөг, гадаад жуулчинд 1500 төгрөг болж байна.

Хамгаалалтын захиргааны үйл ажиллагаа, нутаг дэвсгэрийг хамгаалахад Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д заасны дагуу тооцвол орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэх боломжтой байна. Үүнд:

1. Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөрийн орлого -15 хувь
2. Ан амьтны нөөц ашигласны төлбөрийн орлого – 50 хувь
3. Газрын нөөцийн төлбөрийн орлогын -15 хувь
4. Ойн нөөц ашигласны төлбөрийн орлого – 85 хувь
5. Ус, рашааны нөөц ашигласны төлбөрийн орлого -35 хувь гэж заасны дагуу байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг нөхөн сэргээх арга хэмжээнд тухайн төсвийн жилд зарцуулах хөрөнгийг орон нутгийн төсвөөс хуваарилуулах боломжтой байна.

Аудитаар Байгалийн нөөцийн төлбөрийн орлогоос ойн нөөц ашигласны төлбөрийн орлогыг сонгон 2020-2021 он, 2022 оны эхний хагас жилийн байдлаар төсөвт төвлөрүүлсэн байдлыг хүснэгтээр харуулбал дараах байдалтай байна.

Хүснэгт № 5

Он	Бэлтгэсэн модны хэмжээ /м3/		Төсөвт төвлөрүүлсэн орлого /сая төгрөг/	Эргэн ТХГН-т хуваарилагдах орлого /сая төгрөг/
	Түлшний мод	Хэрэглээний мод		
2019 он	5,266.8	2,137.3	39.8	33.8
2020 он	6,343.7	10,944.4	40.1	34.1
2021 он	9,613.0	2,509.1	132.6	112.7
2022.09	1,204.0	456.9	26.7	22.7
ДҮН	**22,427.5**	**16,047.7**	**239.2**	**203.3**

Үүнээс үзэхэд зөвхөн 2020-2021 онд гэхэд л 203.3 сая төгрөгийг Тусгай хамгаалалттай газар нутгийн ойн нөөцийг нөхөн сэргээхэд зориулах боломжтой байна.

Төсвийн зарцуулалтын талаар: Хамгаалалтын захиргааны 2019-2021 он, 2022 оны эхний хагас жилийн санхүүжилтийн нийт 75 хувийг цалин хөлсөнд, 25 хувийг бусад

зардалд зарцуулж байна. Бусад зардлыг Шатахуун болон бусад зардлыг хог хаягдлыг зайлуулах, судалгаа шинжилгээний ажил, хяналт шалгалт, хууль бус мод бэлтгэлтэд хяналт хийх, сургалт, ойн түймрээс урьдчилан сэргийлэх, эргүүл пост ажиллуулах, сурталчилгаа, ургамал, амьтны хамгаалалт зэрэгт зарцуулсан байна. Хамгаалалтын захиргааны 2019-2021 оны цалингаас бусад төсвийн зарцуулалтыг хүснэгтээр харуулбал дараах байдалтай байна:

Хүснэгт № 6 /сая төгрөг/

№	ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	2021 он		Зардлын дүнд эзлэх хувь
		Төл	Гүйц	
1	Байр ашиглалттай холбоотой зардал	7.3	7.3	6.1
2	хангамж,бараа материал	18.9	18.9	15.8
3	Эд хогшил	0.4	0.4	2
4	томилолт	2	2	
5	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	90.4	90.4	75.9
6	Бараа ажил үйлчилгээний бусад зардал	0.1	0.1	0.2
	Нийт дүн	119.1	119.1	100

Хүснэгтээс харахад: Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөрийн дүнг задалж үзэхэд гэрээт ажлын хөлсний зардалд 37.3 сая, шатахууны зардалд 14.9 сая, отог болон нэвтрэх цэг тохижуулахад 17.7 сая, харуул хамгаалалт, био технологийн зардалд 9.1 сая, томилолт, сурталчилгаанд 11.4 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна. Аудитаар Хамгаалалтын захиргааны төсвийг зориулалтын дагуу зарцуулж ажилласан байна гэж үзлээ.

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн холбогдох заалтын дагуу тусгай хамгаалалтай газар нутгаас ашигласан нөөцийн төлбөрийн орлогоос хуульд заасан хувь хэмжээгээр тооцож орон нутгийн төсвөөс авах, эх үүсвэрийг нэмэгдүүлэх боломжийг алдсан байна.

1.2 Хөвсгөлийн улсын тусгай хамгаалалттай газарт 68 иргэн, аж ахуйн нэгж газар ашиглах зөвшөөрөлгүйгээр жуулчны бааз, гэр буудлын зориулалтаар ашиглаж байна.

Тусгай хамгаалалттай газар нутагт иргэн, аж ахуйн нэгжид тодорхой зориулалт, хугацаа, болзолтойгоор байгаль орчинд сөрөг нөлөөгүй арга, хэлбэрээр гэрээний үндсэн дээр ашиглуулж болохоор заасан бөгөөд газар ашиглах хугацааг 5 жилээс илүүгүй байх тогтоосон байна. Газар ашиглах хугацааг дуусахаас өмнө сунгуулах хүсэлт гаргасан этгээдийн газар ашиглах эрхийг нэг удаад сунгах хугацаа 5 жилээс илүүгүй байхаар хуульчилсан байна.

Хамгаалалтын захиргаа нь хуулиар Тусгай хамгаалалттай газар нутагт шинээр газар ашиглахаар ирүүлсэн хүсэлтийг хүлээн авч тусгай хамгаалалттай газрын менежментийн төлөвлөгөөний зорилго чиглэл, ашиглуулах газрын байршил, хэмжээтэй нийцэж байгаа эсэхийг хянан үзэж нийцсэн бол саналыг БОАЖЯ-нд хүргүүлэх, дээрх саналыг үндэслэн байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийлгэсэн иргэн, аж ахуй нэгжид БОАЖС-ын тушаалаар Тусгай хамгаалалттай газар нутагт газар ашиглуулах эрх олгохоор Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.1[9]-д хуульчилсан байна.

Улсын ТХГН-т газар ашиглах эрхийн зөвшөөрөлтэй 154, зөвшөөрөлгүй 68, сумын Засаг даргын захирамжаар 68, өвөлжөө, хаваржаа зориулалтаар 434 нийт **724** байршилд иргэн, аж ахуйн нэгж газар ашиглаж байна.

[9] Төрийн захиргааны төв байгууллага нь дархан цаазат газрын болон байгалийн цогцолборт газрын хязгаарлалтын бүс, байгалийн нөөц газар, дурсгалт газраас иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад газар ашиглуулах тухай шийдвэрийг хамгаалалтын захиргаа болон сум, дүүргийн Засаг даргын саналыг үндэслэн гаргана.

Газар ашиглалтын байдлыг хүснэгтээр харуулбал: *Хүснэгт № 7*

№	Газар ашиглаж буй хэлбэр	Ашиглагчийн төрөл		Ашиглаж байгаа эсэх					
		Иргэн	Хуулийн этгээд	Аялал жуулчлал	Амралт сувилал	Гэр буудал	Өвөлжөө, хаваржаа, зуслан	Ашигла агүй	Бусад
1	Зөвшөөрөлтэй	43	111	146	2	-	-	-	6
2	Зөвшөөрөлгүй	68	-	4	-	62	1	1	-
3	Сумын Засаг даргын захирамжаар	68	-	1	-	8	27	27	5
4	Өвөлжөө, хаваржаа	434	-	-	-	-	434	-	-
Нийт		**613**	**111**	**151**	**2**	**70**	**462**	**28**	**11**
		724							

Тусгай хамгаалалттай газарт зөвшөөрөлгүйгээр газар ашиглаж байгаа болон сумын Засаг даргын захирамжаар газар ашиглуулж байгаа нь хамгаалалтын захиргаа, БОАЖЯ-ны хяналт сул байгааг харуулж байна.

Алаг-Эрдэнэ сумын Засаг дарга нь 2011 – 2018 онуудад 68 нэгж талбарын газрыг аялал жуулчлал, гэр буудал, өвөл, хаваржаа, зуслангийн зориулалтаар захирамж гарган иргэнд газар ашиглуулсан байна. Энэ нь Газрын тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.2[10], Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.1[11] дэх заалтыг зөрчиж байна. Иймд хууль бус захирамжуудыг хүчингүй болгож, зөрчлийг арилгах албан шаардлагыг Алаг-Эрдэнэ сумын Засаг даргад өгөхөөр шийдвэрлэв.

Тусгай хамгаалалттай газарт шинээр газар ашиглахаар 2019-2022 онд нийт 46 хүсэлтийг хүлээн авч БОАЖЯ-нд газар ашиглах эрх олгох саналыг уламжилсан байна.

Хүснэгт № 8

Огноо	Газрыг олгохыг дэмжсэн санал	Газрын гэрчилгээ сунгуулах санал	Газрын дэмжсэн санал шинэчлэн хүргүүлсэн	Газрын гэрчилгээ шилжүүлэх
2019	10	11	11	0
2020	17	5	0	1
2021	9	25	3	0
2022	10	11	11	0
Нийт	**46**	**52**	**25**	**1**

Хамгаалалтын захиргаа нь менежментийн төлөвлөгөөндөө тусгай хамгаалалттай газар нутагт газар ашиглуулах чиглэл, байршил хэмжээг тогтоосон ерөнхий төлөвлөгөөг зохих мэргэжлийн байгууллагын санал дүгнэлт, судалгааг үндэслэн тусгаагүйгээс шалтгаалан газар ашиглахаар ирүүлсэн хүсэлтийг менежментийн төлөвлөгөөтэй уялдуулан хянах ажлыг хэрэгжүүлээгүй байна.

БОАЖЯ-аас 2019-2022 онд хамгаалалтын захиргааны саналыг үндэслэн Хөвсгөлийн улсын тусгай хамгаалалттай газар нутагт нийт 21-н нэгж талбарт 32.7 га газрыг ашиглуулах шийдвэр гарсан байна. Газар олголтыг хүснэгтээр харуулбал: *Хүснэгт: № 9*

№	Газар ашиглуулах шийдвэр огноо, дугаар	Үйл ажиллагааны чиглэл	Нэгж талбарын тоо	Газрын хэмжээ /га/
1	Байгаль орчин аялал жуулчлалын сайдын 2020.07.02 өдрийн А/534	Аялал жуулчлал	1	0.8

[10] Газрын хэвлий, ой, ус, хийн мандлын агаар, ургамал, амьтан, байгалийн бусад баялгийг ашиглах, хамгаалахтай холбогдсон харилцааг зохих хууль тогтоомжоор зохицуулна.

[11] Төрийн захиргааны төв байгууллага нь дархан цаазат газрын болон байгалийн цогцолборт газрын хязгаарлалтын бүс, байгалийн нөөц газар, дурсгалт газраас иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад газар ашиглуулах тухай шийдвэрийг хамгаалалтын захиргаа болон сум, дүүргийн Засаг даргын саналыг үндэслэн гаргана.

2	Байгаль орчин аялал жуулчлалын сайдын 2020 оны А/211	Аялал жуулчлал	1	1.0
3	Байгаль орчин аялал жуулчлалын сайдын 2020.05.29 өдрийн А/453	Аялал жуулчлал	2	2.9
4	Байгаль орчин аялал жуулчлалын сайдын 2021.06.29 өдрийн А/161	Аялал жуулчлал	1	1.7
5	Байгаль орчин аялал жуулчлалын сайдын 2022.05.09 өдрийн А/156, А/157, А/158, А/159	Үүрэн холбооны дахин дамжуулах станц	4	0.17
6	Байгаль орчин аялал жуулчлалын сайдын 2022.08.22 өдрийн А/317	Аялал жуулчлал	12	26.2
Нийт дүн			21	32.7

Хамгаалалтын захиргаа нь 2019 – 2022 онуудад тусгай хамгаалалттай нутаг дэвсгэрт газар ашиглах эрхийн гэрчилгээ бүхий 38 нэгж талбарын газар ашиглах гэрчилгээг цуцлуулах саналыг 2 удаа албан бичгээр БОАЖЯ-нд хүргүүлж үүнээс 3 нэгж талбарын ашиглах эрхийн гэрчилгээг хүчингүй болгосон ба 35 санал шийдвэрлэгдээгүй байна. *Цуцлахаар хүргүүлсэн саналын жагсаалтыг хавсаргав. /Хавсралт №1/*

Тусгай хамгаалалттай газар нутагт газар ашиглах эрхийн хугацаа дуусгавар болсон боловч хугацаа сунгуулах хүсэлт гаргаагүй 34 иргэн, аж ахуйн нэгжийн газар ашиглах эрхийг Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 40.1.1[12] болон Газрын тухай хуулийн 39.1.1[13]-д заасны дагуу газар ашиглах эрхийг цуцлах саналд тусган эрх бүхий байгууллагад хүргүүлэх нь зүйтэй байна. *Цуцлахаар хүргүүлсэн саналын жагсаалтад ороогүй газар ашиглагч иргэн, аж ахуйн нэгжийн жагсаалтыг хавсаргав Хавсралт №2.*

Зөвшөөрөлгүй газар ашиглалтын талаар:

Хөвсгөлийн улсын тусгай хамгаалалттай газарт 68 иргэн, аж ахуйн нэгж газар ашиглах зөвшөөрөлгүйгээр жуулчны бааз, гэр буудлын зориулалтаар ашиглаж байна.

Аудитын явцад тусгай хамгаалалттай газарт хяналтыг хэрэгжүүлэхэд зөвшөөрөлгүйгээр аялал жуулчлалын үйл ажиллагаа явуулах зорилго бүхий жижиг овортой /3х3/ байшин барьсан мөн нэмж байшин барихаар мод, палк буулгасан байдалтай байв. /Зураг 2, 3/ Дээрх зөрчлийг арилгуулах талаар тухайн нутаг дэвсгэрийг хариуцан хяналт тавьж буй албан хаагчийн зүгээс тодорхой арга хэмжээ авсан зүйл үгүй байна.

Зөвшөөрөлгүй байшин Зураг-1

Мод, палк Зураг-2

Зөвшөөрөлгүйгээр газар ашиглаж байгаа нь тухайн нутаг дэвсгэрийг хариуцан хяналт тавих чиг үүрэг бүхий байгаль хамгаалагч Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуульд заасан чиг үүргээ бүрэн хэрэгжүүлээгүйгээс шалтгаалсан гэж үзэх үндэслэлтэй байна.

[12] Газрын тухай хуулийн 39 дүгээр зүйлд заасан үндэслэлээр;
[13] газар эзэмших эрхийн гэрчилгээ болон газар эзэмших гэрээний хугацаа дуусахад сунгуулах хүсэлт гаргаагүй;

Зөвшөөрөлгүй үйл ажиллагаа явуулдаг иргэн, аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг таслан зогсоож, зөрчлийг арилгаж ажиллах талаар албан шаардлагыг хамгаалалтын захиргаанд өгөхөөр шийдвэрлэв.

Ойн менежментийн төлөвлөгөө гаргаж ажиллаагүй байна.

Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуульд зааснаар Тусгай хамгаалалттай газар нутагт газар, ой, усны нөөцийг ашиглаж болно.

Ойн нөөцийн ашиглалтын тухайд: Аудитад хамрах хугацаанд Тусгай хамгаалалттай газар нутагт газар, ой, ус, түгээмэд тархацтай ашигт малтмалын нөөцийг иргэн аж ахуй нэгжүүдэд ашиглуулсан байна.

БОАЖ-ын сайдын тушаалаар тусгай хамгаалалттай газрын ойн сангийн зөвшөөрөгдсөн бүсэд эрх бүхий ойн мэргэжлийн байгууллагаар ойн арчилгаа, цэвэрлэгээний огтлолт, ойн нөхөрлөлөөр ойн цэвэрлэгээ хийлгэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд хэрэгжүүлж ажиллах талаар шийдвэр гарган ойгоос бэлтгэх модны дээд хязгаарыг жил бүр баталж мөрдүүлдэг байна.

Тусгай хамгаалалттай газар нутгаас бэлтгэх модны дээд хязгаарыг 2019-2022 онд тогтоосон дээд хязгаар болон гүйцэтгэлийг хүснэгтээр харуулбал*:* *Хүснэгт № 10*

Огноо	Арчилгааны огтлолт м3			Цэвэрлэгээний огтлолт м3			Цэвэрлэгээний ажил м3			НИЙТ		
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл		Төлөвлөгөө	Гүйцэтгэл		Төлөвлөгөө	Гүйцэтгэл		Талбай /га/	Мод бэлтгэл /м3/	Тесөвт орсон орлого /сая төгрөг/
		Түлш	хэрэглээ	Төлөвлөгөө	Түлш	хэрэглээ	Төлөвлөгөө	Түлш	хэрэглээ			
2019	5910	1028	563	9040	738.8	374.3	1410	3500	1200	**162**	**7404.1**	**39.8**
2020	7500	358.9	113.7	14000	212.3	4.80	8750	5865.5	975.9	**99**	**7531.1**	**40.1**
2021	7500	3182.7	882.2	14000	306.6	142.2	8750	6336	1,484.70	**155**	**12334.4**	**132.6**
2022	7500			14000			8750	1204.9	456.90	**65.6**	**1661.8**	**26.7**

Хамгаалалтын захиргаа нь хууль бус мод бэлтгэлд тогтмол хяналтыг тавьж ажилладаг ба 2019-2022 оны тайлан мэдээллээс харахад БОАЖС-ын жил бүр баталсан дээд хязгаарт багтаан ойн нөөцийг ашиглуулж ажилласан байна.

Усны нөөц ашиглалтын тухайд: Хөвсгөл нуурын усан орчин /усны мандал/ ашиглаж үйл ажиллагаа моторт завь, усан онгоцны үйлчилгээ үзүүлж буй иргэдэд Хөвсгөл Нуур, Эгийн голын сав газрын захиргаанаас 2022 онд А/07 дугаар тушаалаар 23-н иргэн, аж ахуйн нэгжийн 31-н завинд усан замын тээврийн зориулалтаар усан орчин ашиглах зөвшөөрөл олгосон байна.

Хөвсгөл нуурын усан орчинд үйл ажиллагаа явуулж байгаа иргэн, аж ахуйн нэгжийн бүртгэлийг Далайн захиргаа хөтөлж байгаа бөгөөд 38 иргэн, 19 аж ахуйн нэгж 99 моторт завь, усан онгоцыг Хөвсгөл нуурын усан орчин ашиглаж үйл ажиллагаа явуулж байгаа гэсэн бүртгэлтэй байна.

Хамгаалалтын захиргаанаас нуурын усаар хөвөгч хэрэгсэл /моторт завь, усан онгоц/-д үзлэг шалгалт хийж, нуур, голын усыг нефтийн бүтээгдэхүүн болон хог хаягдлаар бохирдуулахгүй байх нөхцөлийг хангасан тохиолдолд нуурын усаар явах зөвшөөрөл олгож үйл ажиллагаанд нь хяналт тавих чиг үүргийг хэрэгжүүлээгүй байна.

Аудитаар хамгаалалтын захиргааны удирдлагатай хийсэн уулзалтаар хамгаалалтын захиргаанд ус хариуцсан мэргэжилтэн шаардлагатай бөгөөд тусгай хамгаалалттай газар нутгийн онцлогоос шалтгаалан ус, хөрсөнд учруулсан бохирдолд шинжилгээ хийж дүгнэлт гаргах орчин нөхцөл нэн шаардлагатай байгаа саналыг гаргасан.

Усан орчин ашиглаж буй бүртгэлтэй боловч Хөвсгөл нуурт моторт завь ашиглаж буй иргэн, аж ахуйн нэгжээс усан орчин ашигласны төлбөрийг Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1[14]-д заасан дүнгээс тооцон 15.1-д заасан хувь хэмжээгээр төвлөрүүлэх боломжтой байна.

[14] усан цахилгаан станц, усан замын тээвэр, усны амьтан, ургамал өсгөн үржүүлэх, аялал зугаалга, биеийн тамир зэрэг үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар ус, усан орчин ашигласан тохиолдолд тухайн үйлдвэрлэл, үйлчилгээний борлуулалтын орлогын дүнгээс;

Хамгаалалтын захиргаа нь Засгийн газрын 1995 оны 169 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралт “Дархан цаазат болон байгалийн цогцолборт зарим газрын тусгай горим”-д заасан чиг үүргийг хэрэгжүүлэн нуурын усаар хөвөгч хэрэгсэл /моторт завь, усан онгоц/-д үзлэг шалгалт хийж, нуур, голын усыг нефтийн бүтээгдэхүүн болон хог хаягдлаар бохирдуулахгүй байх нөхцөлийг хангасан эсэхэд хяналт тавьж усан орчныг байгаль орчинд сөрөг нөлөөгүйгээр ашиглуулахад анхаарч Далайн захиргаа, Хөвсгөл Нуур, Эгийн голын сав газрын захиргаа, аймгийн байгаль орчин аялал жуулчлалын газартай харилцан уялдаатай ажиллах нь зүйтэй байна.

Хамгаалалтын захиргаа нь Байгаль орчны сайдын 2002 оны 117 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт “Тусгай хамгаалалттай газар нутагт аялал жуулчлал явуулах журам”-ын 5.2[15], Засгийн газрын 1995 оны 169 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралт “Дархан цаазат болон байгалийн цогцолборт зарим газрын тусгай горим”-ын 8.”б”[16]-д моторт завь, усан онгоцонд зөвшөөрөл олгож, үйл ажиллагаанд нь хяналт чиг үүргээ хэрэгжүүлээгүй байна

Түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглалтын тухайд: “Тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх” төслийн хүрээнд “Бээжин юни констракшн групп Монголиа ХХК” нь 2022 онд Хатгал-Жанхай-Тойлогт зэрэг чиглэлийн 37.9 км авто замын байгууламжийг шинээр барих ажлыг гүйцэтгэхдээ тусгай хамгаалалттай газар нутгийн Ардагийн сайраас түгээмэл тархацтай ашигт малтмал буюу хайрга авсан байна.

Дээрх хууль бус үйлдлийг хамгаалалтын захиргаанаас таслан зогсоосон гэх боловч үйл ажиллагааг зогсоож байгаа талаарх мэдэгдэл, акт, талбарт ажилласан ажлын тайлан илтгэх хуудас байхгүй байна.

Тусгай хамгаалалттай газар нутагт хайрга ашиглах бол Хатгал-Ханх, Хатгал-Жанхайн чиглэлийн автомашины замыг “**засаж тохижуулах”-**д ашиглах чулуу, шороо, элс, хайрга авах карьерын цэгийг хамгаалалтын захиргаанаас тогтоож өгөхөөр Засгийн газрын 1995 оны 169 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтад заасан байна.

БОАЖЯ нь хууль тогтоомжоор олгогдоогүй эрх хэмжээг хэрэгжүүлэхээр хэлбэрийн үйлдэл гаргасан байна. ***Тухайлбал:*** БОАЖЯ-аас төсөл хэрэгжүүлэгчид “*2 байршилд ухмал, овоолгыг засаж, хэлбэржүүлэн, гадаргыг налуулан, хар шороон хөрсөөр хучиж*, *техникийн нөхөн сэргээлт хийх ажлыг гүйцэтгэхэд татгалзах зүйлгүй”* гэсэн агуулгатай хариуг албан бичгээр хүргүүлсэн нь тусгай хамгаалалттай газар нутагт түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглах эрх олгосон шийдвэр биш юм.

Газар ашиглах хугацааг сунгуулах хүсэлт гаргаагүй нэгж талбарын газар ашиглах эрхийг цуцлуулах саналыг тухай бүр Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлээгүй, зөвшөөрөлгүй газар ашиглалтын зөрчлийг таслан зогсоох талаар хамгаалалтын захиргаанаас арга хэмжээ авч ажиллаагүй байгаагаас үзэхэд тусгай хамгаалалттай газар нутагт газар олголт, ашиглалтын байдалд тавих хяналт сул, төрийн байгууллага чиг үүргээ бүрэн хэрэгжүүлээгүй нь харагдаж байна.

[15] 2. аялал жуулчлалын чиглэлээр сум, дүүргийн Засаг дарга, аялал жуулчлалын үйл ажиллагаа явуулах аж ахуйн нэгж, байгууллагатай газар ашиглах гурвалсан гэрээ байгуулах, гэрээний биелэлтийг хангуулах арга хэмжээ авах

[16] нуурын усаар хөвөгч хэрэгсэл /моторт завь, усан онгоц/-д үзлэг шалгалт хийж, нуур, голын усыг нефтийн бү-тээгдэхүүн болон хог хаягдлаар бохирдуулахгүй байх нөхцөлийг хангасан тохиолдолд нуурын усаар явах зөвшөөрөл олгож. үйл ажиллагаанд нь хяналт тавих ;

БҮЛЭГ 2. ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ ГАЗАР НУТАГТ ГАЗАР АШИГЛАЖ БАЙГАА ИРГЭН, АЖ АХУЙН НЭГЖҮҮДЭЭС ГАЗАР АШИГЛАСНЫ ТӨЛБӨРИЙГ ОРОН НУТГИЙН ТӨСӨВТ БҮРЭН ТӨВЛӨРҮҮЛЭЭГҮЙ БАЙНА.

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль, Газрын тухай хууль, Газрын төлбөрийн тухай хуультай нийцэж байна.

Газрын суурь болох Газрын тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.2-т “Газрын хэвлий, ой, ус, хийн мандлын агаар, ургамал, амьтан, байгалийн бусад баялгийг ашиглах, хамгаалахтай холбогдсон харилцааг зохих хууль тогтоомжоор зохицуулна” гэж заасны дагуу улсын тусгай хамгаалалттай газар нутгийн газартай холбоотой харилцааг Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулиар зохицуулж байна. Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн холбогдох заалт нь Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль, Газрын тухай хууль, Газрын төлбөрийн тухай хуультай нийцэж байна.

Тусгай хамгаалалттай газар нутгийн хуулийн холбогдох заалт бусад хуулийн заалттай нийцээгүй дараах тохиолдол илэрч байна. ***Үүнд:***

1. Тусгай хамгаалалтын газар нутгийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.4[17]-т зааснаар тусгай хамгаалалттай газар нутагт учруулсан хохирол нь Тусгай хамгаалалттай газар нутгийг хамгаалах ажлыг санхүүжүүлэх хөрөнгийн эх үүсвэр болохоор хуульчилсан гэтэл Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.1[18]-т нөхөн төлбөрийн орлогыг Байгаль орчин, уур амьсгалын санд оруулахаар мөн давхар хуульчилсан байна.Энэхүү хуулийн давхардал нь 2022 онд тусгай хамгаалалттай газар нутагт илрүүлсэн хууль бус ангийн хохирлын нөхөн төлбөр дээр маргаан үүсгэж анхан шатны шүүхийн шийдвэрээр Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн санд төвлөрүүлэх нь зүйтэй гэж үзсэн байна. Шүүхээс ингэж шийдвэрлэсэн ч нэг зүйлийг 2 хуулиар зохицуулсан хэвээрээ байна.
2. Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.8[19], 27.9[20]-т тус тус зааснаар БОАЖЯ нь тусгай хамгаалалттай газар нутагт ашиглуулах газрын хэмжээ, байлгаж болох малын төрөл тоог тогтоох эрхтэй байна. Гэтэл тус хуулийн 30 дугаар зүйлийн 30.10[21]-т зааснаар Хамгаалалтын захиргааны бүрэн эрхэд мөн дээрх эрх хадгалагдаж байна. Одоог хүртэл хамгаалалттай газар нутагт ашиглуулах газрын хэмжээ, байршил, байлгаж болох малын төрөл тоог тогтоох ажлыг аль аль тал нь хэрэгжүүлээгүй байна.

Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль болон Байгаль орчныг хамгаалах тухай хуулийг нийцүүлэн өөрчлөх шаардлагатай байна.

Тусгай хамгаалалттай газар нутагт газар ашиглах эрхийн зөвшөөрөлтэй иргэн, аж ахуйн нэгжийн нэгж талбарын мэдээллийг газрын кадастрын дундын мэдээллийн санд бүртгэх эрхийг хамгаалалтын захиргааны газар ашиглалт хариуцсан ажилтанд олгогдсон байна. Газрын мэдээллийн санд нэгж талбарын мэдээллийг бүрэн оруулснаар газрын төлбөрийг хуульд заасан хувь хэмжээгээр ногдуулах эрх үүсдэг байна.

Тусгай хамгаалалттай газар нутагт газар ашиглах зөвшөөрөлтэйгөөр үйл ажиллагаа явуулж буй 154 иргэн, аж ахуйн нэгж байгаагаас газрын мэдээллийн нэгдсэн системд 98 нэгж талбарын мэдээллийг оруулж, 56 нэгж талбарын мэдээллийг оруулаагүй байна.

[17] тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль тогтоомж зөрчсөн этгээдийн учруулсан хохирлын нөхөн төлбөрийн орлого.
[18] Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь байгаль орчин болон байгалийн нөөцөд хохирол учруулсан бол нөхөн төлбөр төлөх бөгөөд нөхөн төлбөрийг Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 7 дугаар зүйлд заасан Байгаль орчин, уур амьсгалын санд оруулна.
[19] / тусгай хамгаалалттай газар нутгийн зөвшөөрөгдсөн бүс дэх суурин газрын ерөнхий төлөвлөгөө, шинээр байгуулах аялал, жуулчлалын бааз, амралт, сувиллын байршил, төслийг холбогдох төрийн захиргааны төв байгууллагуудтай хамтран хянан батлах;
[20] тусгай хамгаалалттай газар нутгийн зөвшөөрөгдсөн бүсэд тодорхой зориулалтаар ашиглаж болох газар, түүний хэмжээ, ашиглах журам, уг газарт байлгаж болох малын төрөл, тоог тогтоох;
[21] зөвшөөрөгдсөн бүсэд байлгаж болох малын төрөл, тоо болон зохих журмын дагуу иргэн, аж ахуйн нэгж,байгууллагад ашиглуулах газрыг тогтоох.

Газрын кадастрын дундын мэдээллийн санд суурь бүртгэлийг оруулсан байдлыг хүснэгтээр харуулбал дараах байдалтай байна: *Хүснэгт № 11*

Газрын нэгдсэн мэдээллийн санд орсон зөвшөөрөлтэй газрын мэдээлэл							
№	Тусгай хамгаалалттай газар нутагт хамаарах сумын нэр	Нийт зөвшөөрөлтэй газрын		Мэдээллийн санд орсон газрын		Мэдээллийн санд ороогүй газрын	
		Тоо	Хэмжээ /га-гаар/	тоо	Хэмжээ /га-гаар/	тоо	Хэмжээ /га-гаар/
1	Алаг-Эрдэнэ	117	418.2	74	183.2	43	235.0
2	Чандмань-Өндөр	20	100.6	9	30.1	11	70.5
3	Ханх	12	132.2	11	102.2	1	30.0
4	Рэнчинлхүмбэ	5	14.2	4	11.2	1	3.0
	Нийт дүн	**154**	**665.2**	**98**	**326.7**	**56**	**338.5**

Тусгай хамгаалалттай газар нутагт газар ашиглаж буй иргэн, аж ахуй нэгжийн мэдээллийг газрын кадастрын дундын мэдээллийн санд суурь бүртгэлийг хөтлөх, Хамгаалалтын захиргаанд цаг тухай бүрд нь эрх бүхий байгууллагаас мэдээлэл оруулах эрхийг нээж өгөөгүйгээс шалтгаалсан байна. Газрын кадастрын дундын мэдээллийн санд орсон суурь бүртгэлийг үндэслэн, тусгай хамгаалалттай газар нутагт хамаарах сумын газрын даамал нэхэмжлэх үүсгэж, татварын байцаагч нэхэмжлэлийн дагуу төлбөрийг төвлөрүүлэх үүрэгтэй.

Газрын мэдээллийн системд бүртгэх, төлбөр ногдуулах, төлбөрийг төвлөрүүлж буй дараалыг дүрслэлээр харуулбал. *Дүрслэл № 2*

Тусгай хамгаалалттай газар нутагт газар ашиглаж, газрын нэгдсэн мэдээллийн санд мэдээлэл нь орсон 98 газар ашиглагч иргэн, аж ахуйн нэгжээс 37 газар ашиглагчийн 35.3 сая төгрөгийн өр /хавсралт №3/ барагдаагүй байна. Газрын төлбөрийн 2020-2022 оны төлөлтийг хүснэгтээр харуулбал дараах байдалтай байна. *Хүснэгт № 12*

Тусгай хамгаалалттай газар нутагт хамаарах сумын нэр	Газрын нэгдсэн мэдээллийн санд мэдээлэл орсон нэгж талбарын газрын төлбөр					
	Газрын хэмжээ /га/	Тухайн жилд ногдох газын төлбөр /сая төг/	Газрын төлбөр төлөөгүй /сая төг/			
			2020 он	2021 он	2022 он	Нийт өр /сая төг/
Алаг-Эрдэнэ	183.2	30.4	0.9	4.5	9.7	15.1
Чандмань-Өндөр	30.1	23	1.7	1.7	7.5	10.9
Ханх	63.2	19.0	0	4.4	4.4	8.8
Рэнчинлхүмбэ	11.2	1.5	0.15	0.15	0.15	0.45
Нийт дүн	**287.7**	**73.9**	**2.8**	**10.8**	**21.8**	**35.3**

Хүснэгтэн мэдээллээс харахад 2020-2022 онд ногдох газрын төлбөрөөс 35.3 сая төгрөгийг төлүүлээгүй байгаа нь дээрх сумын татварын байцаагч нар хариуцлагагүй үйл ажиллагаанаас шалтгаалсан байна. Зөрчилд төлбөрийн акт тогтоохоор шийдвэрлэв.

Газрын нэгдсэн мэдээллийн санд бүртгэлтэй боловч газар ашиглах эрхийн зөвшөөрөл, гэрээний хугацаа дуусан 20 нэгж талбарын 119 га газар байна. Тус газруудад ногдож болох газрын төлбөрийг хүснэгтээр харуулбал дараах байдалтай байна:

Хүснэгт № 13

№	Тусгай хамгаалалттай газар нутагт хамаарах сумын нэр	Газрын нэгдсэн мэдээллийн санд бүртгэлтэй боловч гэрээний хугацаа дуусанаас нэхэмжлэл үүсээгүй газар			
		тоо	Хэмжээ /га-гаар/	Жилд ногдох газрын төлбөр /сая төг/	2020-2022 онд ногдох газрын төлбөр /сая төг/
1	Алаг-Эрдэнэ	11	36.2	10.9	21.7
2	Чандмань-Өндөр	1	0.9	0.27	0.7
3	Ханх	6	41.6	12.5	30
4	Рэнчинлхүмбэ	1	1.3	0.2	0.5
	ДҮН	**19**	**80**	**23.87**	**52.9**

Тусгай хамгаалалттай газар нутагт газар ашиглах зөвшөөрлийн хугацааг сунгуулаагүйгээс нэхэмжлэл үүсэхгүй, төлбөр авах боломжгүй болсон үчир дээрх **19 иргэн, аж ахуйн нэгжээс 2020-2022 онд 52.9 сая төгрөгийн газрын төлбөрийг ногдуулах боломжгүй болсон байна.** Энэ нь газар ашиглагч иргэд цаг тухайд нь газрын зөвшөөрлөө сунгуулах үүргээ биелүүлээгүй, хамгаалалтын захиргаанаас шаардлага тавиагүй, **гол нь заавал цахим программаар нэхэмжлэл үүсгэж байж төлбөр авах тогтолцоотой холбоотой байна.**

Тусгай хамгаалалттай газар нутагт аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа 56 иргэн, аж ахуйн нэгжийн 243.2 га газрын мэдээллийг Кадастрын мэдээллийн санд оруулаагүй байна. Газрын мэдээллийн нэгдсэн санд оруулаагүй газрын төлбөрийг хүснэгтээр харуулбал дараах байдалтай байна: *Хүснэгт №14*

д/д	Хөвсгөлийн БЦГ-т хамаарах сумын нэр	Газрын нэгдсэн мэдээллийн санд бүртгэгдээгүй газар			
		Газрын хэмжээ /га/	Газрын нэгж талбар /тоо/	Тухайн жилд ногдож газрын төлбөр /сая төг/	2020-2022 онд ногдох газрын төлбөр /сая төг/
1	Алаг-Эрдэнэ	139.7	43	35.2	54.9
2	Чандмань-Өндөр	70.5	11	10.3	30.9
3	Ханх	30	1	2.4	7.2
4	Рэнчинлхүмбэ	3	1	0.4	1.2
Нийт		**243.2**	**56**	**48.3**	**94.2**

Тусгай хамгаалалттай газар нутагт үйл ажиллагаа явуулж буй иргэн, аж ахуй нэгжийн газар ашиглалттай холбоотой мэдээллийг газрын мэдээллийн нэгдсэн сан буюу лэнд менежер системд оруулаагүйгээс газрын төлбөрийн нэхэмжлэл үүсгэн, ногдуулалт хийж, 2020-2022 онд 94.2 сая төгрөгийн газрын төлбөрийг төсөвт төвлөрүүлэх боломжийг алдсан байна.

Газрын төлбөрийн орлогын ногдуулалт, төлөлттэй холбоотой дээрх зөрчлүүд нь газрын мэдээллийн нэгдсэн сан буюу Лэнд менежер системд оруулаагүй зэрэг шалтгаанаар газрын төлбөрийн ногдол буюу нэхэмжлэл үүсэхгүй байхаар программчлагдсантай холбоотой байдлаар албаны хүмүүс тайлбарлаж байна.

Энэ нь Хамгаалалтын захиргааны газар ашиглалт хариуцсан мэргэжилтэн хуульд заасан чиг үүргээ бүрэн хэрэгжүүлээгүйтэй холбоотой байна.

Дээрх зөрчилтэй асуудлууд нь тусгай хамгаалалтай газрын мэргэжилтэн, тухайн газар нутгийг хариуцсан байгаль хамгаалагч, холбогдох сумдын газрын даамал, татварын байцаагч нарын ажлын уялдаа холбоо байхгүй, хариуцлагагүй үйл ажиллагаатай холбоотой байна гэж аудитаар үзэж байна.

2.2 БОАЖЯ-аас байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийлгээгүй иргэн, аж ахуй нэгжид газар ашиглуулах шийдвэр гаргасан байна.

Тусгай хамгаалалттай газар нутагт эрх бүхий байгууллагын зөвшөөрөлтэй үйл ажиллагаа явуулж байгаа иргэн, аж ахуйн нэгжийн хувийн хэргийг тулган үзэхэд байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээ хийлгээгүй **74,** нарийвчилсан үнэлгээ хийлгээгүй **98** иргэн, аж ахуйн нэгжийн үнэлгээг тус тус хийлгээгүй байна. Үүнийг дүрслэл №3-аар

харуулбал:

Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас газар ашиглах гэрчилгээг олгохоос өмнө байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий болон нарийвчилсан үнэлгээ хийлгэх талаар холбогдох хууль тогтоомжид заасан боловч газар ашиглах эрх олгож, гэрчилгээ олгосон байна.

Газар ашиглах эрх авах болон төсөл хэрэгжүүлэхээс өмнө байгаль орчны ерөнхий болон нарийвчилсан үнэлгээг хийлгээгүй байгаа нь Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2[22], Байгаль орчны сайдын 2001 оны 218 дугаар тушаалаар баталсан “Тусгай хамгаалалттай газар нутагт газар ашиглах зөвшөөрөл олгох түр журам”-тай тус тус нийцэгүй байна.

Тусгай хамгаалалттай газар нутагт газар ашиглагч нь байгаль орчны нөлөөллийн ерөнхий болон нарийвчилсан үнэлгээ хийлгээгүй байхад БОАЖЯ-аас газар ашиглуулах эрх олгож байгаа нь байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлэх эрсдэлийг дагуулах үндэслэл болж байна.

БҮЛЭГ 3. *ХАМГААЛАЛТЫН ЗАХИРГААНЫ ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ ГАЗАР НУТГИЙГ ХАМГААЛАХ АЖИЛ ХАНГАЛТГҮЙ БАЙНА.*

Хамгаалалтын захиргаа нь Тусгай хамгаалалттай газар нутагт ой, хөрс, ургамал, ан амьтан бүхий газар нутгийг хадгалах, хамгаалах ажлыг судалгаа, шинжилгээнд үндэслэж хийгээгүйгээс ажлын үр дүнг тодорхойлох боломжгүй, хуульд заасан чиг үүрэг, менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан ажлын биелэлт хангалтгүй байна.

Хамгаалалтын захиргаа нь Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 30 дугаар зүйлд заасан хуулиар тодорхойлсон үндсэн чиг үүргээс гадна менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан үйл ажиллагааг хэрэгжүүлж ажиллаж байна.

[22] Байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээг байгалийн нөөцийг ашиглах, газрын тос болон ашигт малтмал хайх, ашиглах, аж ахуйн зориулалтаар газар эзэмших, ашиглах эрх авах болон төсөл хэрэгжүүлэхээс өмнө хийнэ.

Хамгаалалтын захиргааны менежментийн төлөвлөгөө 2014, 2022 онуудад батлагдсан бөгөөд 2014 онд батлагдсан төлөвлөгөөг 2014-2018 оны хугацаанд хэрэгжүүлэх байсан боловч 2019-2020 онуудад үргэлжлүүлэн хэрэгжүүлэхээр хугацааг сунгасан байна.

Шалтгаан нь “Юнескогийн хүн ба шим мандлын нөөц газрын жагсаалтад бүртгэгдэж, Азийн хөгжлийн банкны төсөл хэрэгжих тул түүнтэй үйл ажиллагаагаа уялдуулан төлөвлөнө” гэсэн үндэслэлээр хойшлуулсан байна.

Менежментийн шинэчилсэн төлөвлөгөө 2022 онд батлагдах хүртэл буюу 2021, 2022 онуудад менежментийн төлөвлөгөөгүй үйл ажиллагаагаа явуулсан байна.

Хамгаалалтын захиргаа нь 2014-2020 оны менежментийн төлөвлөгөөнд Хөвсгөл нуур, Рашаан булаг, Зэвэг, Цагаан сүүлт бүргэд, Вансэмбэрүү, Уулын хээрийн бүлгэмдэл, Сибирь хандгай, Янгир, Шинэсэн ой гэх 9 үнэт зүйлсийг сонгон хамгаалах, үр дүнд хүрэхийг үндсэн чиглэл болгосон байна.

Менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан хамгаалах үнэт зүйлс болон төлөвлөсөн үр дүнд хүрсэн эсэх байдлыг үнэлбэл дараах байдалтай байна: *Хүснэгт №15*

д/д	Хамгаалах үнэт зүйлс	Хүрэх үр дүн	Хийгдсэн ажил	Үр дүн
1	Хөвсгөл нуур	Тунгалагшилтыг хэвийн хэмжээнд буюу 24м-т байлгана	2020, 2022 онд Мэргэжлийн хяналтын газрын хяналтын хүрээнд тодорхой цэгүүдээс дээж авхуулж бохирдол, найрлагыг тогтоолгож ажилласан нийт нуурын усны тунгалагшилд, бохирдлын талаар судалгаа хийгээгүй байна.	Хангалтгүй
2	Рашаан булаг	Хөвсгөлийн байгалийн цогцолбор газар байгаа 47 рашаан булгийн 50% буюу 24 рашаан булгийг 2018 он гэхэд хамгаалсан байна.	Аудитад хамаарах 2019-2022 онд рашаан, булгийг хамгаалж, хашаалах ажил хийгдээгүй байна. 2018 оноос өмнөх хугацаанд 5 рашаан булгийн эхийг хамгаалж хашаа хийсэн байна.	Хангалтгүй
3	Зэвэг загас	2020 он гэхэд зэвэг загасны тоо толгой 2013 оны суурь үзүүлэлтээс дээшилсэн байна.	Зэвэг загасны тоо судалгаа хийж суурь үзүүлэлтийг тооцоогүй байна.	Хангалтгүй
4	Цагаан сүүлт бүргэд	Цагаан сүүлт бүргэдийн биологи, экологийн талаар бүрэн судалгаатай болсон байна	Цагаан сүүл бүргэдийн талаар ажиглалт хийж, ажиглалтад өртсөн газар, тооны мэдээ гаргасан боловч биологи, экологийн талаар бүрэн судалгаа гаргасан зүйл үгүй байна. Ажиглалтад өртсөн тоо 2019-2021 онуудад харилцан адилгүй өсөлт, бууралтыг тооцох боломжгүй байна.	Хангалтгүй
5	Вансэмбэрүү	Хууль бус ашиглалтыг 50% бууруулсан байна.	Вансэмбэрүү цэцгийн талаар ажиглалт хийж мэдээ гаргасан боловч цаашид авах арга хэмжээний талаар төлөвлөгөө гаргаагүй , хууль бус ашиглалттай холбоотой зөрчил илэрсэн тохиолдол байхгүй тул үр дүнг тооцох боломжгүй байна.	Хангалтгүй
6	Уулын хээрийн бүлгэмдэл	2020 он гэхэд 1м2 талбайд байх ургамлын зүйлийн тоо 7-9 болж сэргэсэн байна.	Уулын ургамлын бүлгэмдлийн талаар тооцоо, судалгаа хийгээгүй байна.	Хангалтгүй

7	Сибирь хандгай	Хандгайн популяци, тархац, идээшил, амьдрах орчны бүрэн судалгаатай болсон байна	Хандгай харагдсан ажиглалтын мэдээ гаргасан боловч хандгайн талаар бүрэн судалгаа гаргаагүй байна.	Хангалтгүй
8	Янгир	2020 он гэхэд янгирын тоо толгой 200-д хүрсэн байна	Ажиглалтын мэдээнээс үзэхэд БЦГ-ын бүсэд 2018 онд – 3, 2019 онд – 28, 2020 онд – 41, 2021 онд – 42 тус тоологдсон бөгөөд янгирын тоо толгой өсөх хандлага ажиглагдсан байна. Янгир ямааны өсөлтөөс шалтгаалан Хөвсгөлийн улсын тусгай хамгаалалтын газар нутагт цоохор ирвэс 2020 онд ажиглагдсан байна.	Дунд
9	Шинэсэн ой	Ой зохион байгуулалт бүрэн хийгдэж хэрэгжиж эхэлсэн байна	Ойн нөөцийг хамгаалах чиглэлээр тогтмол хяналтыг хийж ажиллаж байгаа боловч ойн зохион байгуулалтын төлөвлөгөө гаргаж ажиллаагүй. Хүрэх үр дүн тодорхойгүй, системтэй ашиглалт байхгүй байна.	Дунд
Биелэлтийн ерөнхий дүн				**Хангалтгүй**

Менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний биелэлт хангалтгүй буюу хүрэх үр дүндээ бүрэн хүрээгүй байна.

Үүнд дараах хүчин зүйлс нөлөөлсөн байна:

1. Үр дүнг тодорхойлоход хэцүү зорилтыг менежментийн төлөвлөгөөнд тусгасан. Зэвэг загасны тоо толгойг өсгөх, Вансэмбэрүү цэцгийн хууль бус ашиглалтыг бууруулах, 1 м.кв талбайд байх ургамлын зүйлийн тоог 7-9 болгож сэргээх, хандгай, цагаан сүүлт бүргэдийн талаар иж бүрэн судалгаатай болсон байх, янгирын тоо толгойг 200-д хүргэх зэрэг зорилтууд богино, дунд хугацаанд хэрэгжих боломжгүй их хугацаа, хөрөнгө шаардсан ажлууд байна.
2. Менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд хариуцлагагүй хандсан байна. Хамгаалалтын захиргаанаас бие даан хэрэгжүүлэх боломжтой Хөвсгөл нуурын тунгалагшилтыг 24 метрт байлгах, рашаан булгийг хашиж хамгаалах, ойн зохион байгуулалт хийх зэрэг ажлуудыг бодитой судалгаа, шинжилгээтэй хийж ажиллаагүй байна. Жишээ нь: Хөвсгөл нуурын уснаас тогтмол дээж авч шинжлүүлэн тунгалагшилт, бохирдол нь ямар хэмжээнд байгаа талаар судалгаа хийж ажиллаагүй байна. Дээрх ажлыг аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төвтэй хамтран гүйцэтгэх бүрэн боломжтой юм.
3. Удирдлагын тогтворгүй байдал ажлын үр дүнд сөргөөр нөлөөлсөн байна. *Тухайлбал:* Хамгаалалтын захиргааны даргаар 2018 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс 2022 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн хугацаанд 4 удаа солигдсон байна.

Хамгаалалтын захиргааны хуулиар хүлээсэн чиг үүргийн хэрэгжилт дараах байдалтай байна:

Хүснэгт №16

Д/д	Чиг үүрэг	Хийгдсэн ажил	Үр дүн
1	Тусгай хамгаалалттай газар нутгийн талаарх хууль тогтоомж, тухайн газар нутгийн хамгаалалтын горимын биелэлтийг хангуулах;	Хамгаалалтын горимыг сахиулах ажлын чиглэлээр хулгайн мод бэлтгэл, хууль бус ан агнуур, загас агнуур, гэр буудал, амралтын газруудын хог хаягдал, бохирын менежмент, ашиглалтын байдалд тогтмол хяналтыг хэрэгжүүлж ажилласан байна. Харин газар, ус ашиглалтын чиглэлээр үр дүн муутай ажилласан байна. Энэ нь нуурын эрэг орчмын зөвшөөрөлгүй болон зөвшөөрлийн хугацаа нь	Дунд

		дууссан гэр буудал, амралтын газрууд олон байгаагаар дүгнэгдэж байна.	
2	Судалгаа, шинжилгээ хийх зөвшөөрөл авсан байгууллагатай гэрээ байгуулах, тухайн газар нутгийн хамгаалалтын горимын хүрээнд явуулж болох үйл ажиллагаанд зөвшөөрөл олгох, хяналт тавих;	2019 онд судалгаа, шинжилгээ хийх зөвшөөрөл авсан 5 байгууллагын судалгаанд хяналт хийж ажилласан байна. 2020-2022 онд гэрээт судалгаа хийгдээгүй байна.	Хангалттай
3	Зохих журмын дагуу судалгаа, шинжилгээний зориулалтаар дээж, сорьц авах, ан амьтны сүргийн бүтцийг зохицуулах, байгалийн баялгийг нөхөн сэргээх, ойд арчилгаа, цэвэрлэгээ хийх;	2020, 2022 онд Мэргэжлийн хяналтын газрын хяналтын хүрээнд тодорхой цэгүүдээс дээж авхуулж бохирдол, найрлагыг тогтоолгосон, ойн арчилгаа цэвэрлэгээний төсөл сонгон шалгаруулалтыг жил бүр хийж үнэлэн арчилгаа, цэвэрлэгээ хийх хэмжээг тогтоож ажилласан бол ан амьтны сүргийн бүтцийг зохицуулах ажил хийгдээгүй байна. Ан амьтдын тоо, толгойг тодорхойлох зорилгоор 2020 онд БОАЖЯ, Дэлхийн байгаль хамгаалах сангийн дэмжлэгтэйгээр Улаан тайгын УТХГХЗ-тай хамтран 15 ширхэг камер байрлуулан ажиллуулсан байна.	Дунд
4	Ан амьтанд зориулан ус задгайлах, хадлан бэлтгэх, өвс тэжээл, хужир, шүү тавих, нөмөр хорго барих болон биотехникийн бусад арга хэмжээг зохих журмын дагуу гүйцэтгэх;	Ан, амьтанд зориулсан ус задгайлах, хадлан өвс бэлтгэж тавих, хужир, шүү тавих жил бүр тогтмол хийж ирсэн байна.	Хангалттай
5	Рашаан, эмчилгээ, сувилгааны зориулалттай эрдэс, байгалийн дагалт баялгийг зохих журмын дагуу ашиглуулах;	Хөвсгөл нуурын эрэгт орших Хар усны рашаанаар үйлчлүүлж буй иргэдэд жил бүр тогтмол хяналт тавьж ажилласан байна.	Хангалттай
6	Зөвшөөрөгдсөн аялал, жуулчлалын зам, чиглэлийг тэмдэгжүүлэх, шаардлагатай орон байр барих, тээврийн хэрэгслийн зогсоол гаргах, биеийн тамирын болон нийтийн бусад арга хэмжээ явуулах газар, журмыг тогтоох, эрүүл ахуйн нөхцөлийг нь хангах, тэдгээрийг иргэд, аж ахуйн нэгж, байгууллагатай хамтран тохижуулах;	Хөвсгөл нуурын эрэг орчмын гэр буудал амралтын газруудад тогтмол хяналт тавьж, эрүүл ахуй, тохижилт, талаар жил бүр арга хэмжээ авч ажилласан бол аялал жуулчлалын зам чиглэлийг тэмдэгжүүлэх, биеийн тамирын болон нийтийн бусад арга хэмжээг явуулах газар, журмыг тогтоогоогүй байна.	Дунд
7	Зөвшөөрөгдсөн бүс дэх сууринг тохижуулах, барилга байгууламж барих ажлыг батлагдсан төлөвлөгөөний дагуу гүйцэтгэж байгаад хяналт тавих;	Зөвшөөрөгдсөн бүс дэх сууринг тохижуулах, барилга байгууламж барих ажлын төлөвлөгөө батлагдаагүй байна.	Хангалтгүй
8	Уул, овоо тахих, уламжлалт зан үйлийн бусад ёслол үйлдэх ажиллагааг зохицуулах;	Уул, овоо тахих, уламжлалт зан үйлийн бусад ёслол үйлдэх ажиллагаа зохион байгуулагдаагүй байна.	Хангалттай
9	Тусгай хамгаалалттай газар нутгийн ач холбогдол, хамгаалалтын горим, холбогдох хууль тогтоомжийг сурталчлан таниулах, он дараалын бичиг хөтлөх, мэдээллийн сан бүрдүүлэх;	Сургалт сурталчилгааг иргэн, аж ахуй нэгж байгууллага, аялагчдад тогтмол танилцуулж ажилласан байна.	Хангалттай
10	Зөвшөөрөгдсөн бүсэд байлгаж болох малын төрөл, тоо болон зохих журмын дагуу иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад ашиглуулах газрыг тогтоох.	Зөвшөөрөгдсөн бүсэд байлгаж болох малын төрөл, тоо болон иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад ашиглуулах газрыг тогтоож ажиллаагүй байна.	Хангалтгүй
	Биелэлт		**Дунд**

Хамгаалалтын захиргаа нь хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлэхдээ хамгаалалт, хяналт шалгалтад илүү төвлөрч сайн ажилласан боловч мэргэжлийн байгууллага, судлаач эрдэмтэдтэй хамтран судалгаа, шинжилгээ хийж ажиллаагүй байна. Судалгаа, суурь үзүүлэлтэд үндэслээгүй хамгаалалт нь үр дүн багатай, хамгаалалтын захиргааны эрх, хэмжээний хүрээнд шийдвэрлэж болох хамгаалалтын бүсэд байлгаж болох малын төрөл, тоо болон иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад ашиглуулах газрыг тогтоогоогүйгээс нуурын эрэг орчим газар ашиглах явдал хавтгайрсан байна.

Аудитад хамрагдах хугацаанд Азийн хөгжлийн банкнаас Аялал жуулчлалыг тогтвортой хөгжүүлэх 2019-2022 төсөл, Засгийн газрын 2019 оны 332 дугаар тогтоолоор батлагдсан “Хөвсгөл нуур орчмын “Эко аялал жуулчлалын бүсийг хөгжүүлэх төлөвлөгөө”-хэрэгжүүлэхэд хамтран ажиллаж, зарим төсөл арга хэмжээний хэрэгжилтэд хяналт хийн ажилласан байна. Одоогийн байдлаар тус төслийн хүрээнд дараах ажлууд хэрэгжиж байна:

1. Хамгаалалтын захиргааны 2022-2026 он Менежментийн төлөвлөгөөг боловсруулахад санхүүжилтийг шийдвэрлэж 2022 онд Хамгаалалтын захиргааны Менежментийн төлөвлөгөөг батлуулсан,
2. Хатгал-Жанхай-Тойлогт чиглэлд 37,9 км хатуу хучилттай зам тавих ажлыг эхлүүлж, замын суурь далан барих ажлыг гүйцэтгэж байна.

Ковид-19 цар тахлаас шалтгаалан олон улсын туршлагыг судлах, нэвтрүүлэх ажил хийгдээгүй байна.

Хамгаалалтын захиргаа нь 2019 оноос 2022 онд Юнеско-ийн хүн ба шим мандлын нөөц газрын жагсаалтад бүртгүүлэх ажлыг зохион байгуулж 2022 онд бүртгүүлж батламж авсан байна. Энэ нь ТХГН-ийг хамгаалах, олон улсын туршлагыг судлан нэвтрүүлэхэд чухал ач холбогдол бүхий ажил болжээ.

Ковид-19 цар тахлаас шалтгаалан аудитад хамрах онуудад олон улсын сайн туршлагыг судлах, нэвтрүүлэх ажил хийгдээгүй байна.

Хамгаалалтын захиргаа нь Тусгай хамгаалалттай газар нутагт ой, хөрс, ургамал, ан амьтан бүхий газар нутгийг хадгалах, хамгаалах ажлыг судалгаа, шинжилгээнд үндэслэж хийгээгүйгээс ажлын үр дүнг тодорхойлох боломжгүй, хуульд заасан чиг үүрэг, менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан ажлын биелэлт хангалтгүй байна.

БҮЛЭГ 4. Хамгаалалтын захиргаа, сумдын Засаг дарга нар газар ашиглаж буй иргэн аж ахуйн нэгжтэй байгуулсан гуравласан гэрээний биелэлтийг дүгнэх, биелэлтийг хангуулах ажлыг хамтран зохион байгуулаагүй байна.

БОАЖЯ-аас Хамгаалалтын захиргааны үйл ажиллагаанд хяналт хийж ажиллаагүй байна. Харин ТХГН-ийн газар, орчинд хяналт хийсэн гэсэн мэдээлэл байгаа боловч хамгаалалтын захиргаанд тайлан, зөвлөмж өгөөгүй байна. Аймгийн Засаг дарга, БОАЖГ, сумын Засаг дарга нараас хяналт хийж ажиллаагүй байна.

Сумын Засаг дарга нь Байгаль орчны сайдын 2001 оны 218 дугаар тушаалын 2 дугаар хавсралтаар батлагдсан гэрээний үндсэн нөхцөлүүдэд заасан чиг үүргийн хүрээнд газар ашиглах этгээдтэй байгуулсан гуравласан гэрээнд заасан газар ашиглагчийн төлбөрийн мэдээллийг холбогдох байгууллагад хүргүүлэх, газрын төлбөрийг бүрэн ногдуулж төсөвт төвлөрүүлэх гэрээнд заасан эрх, үүргээ бүрэн хэрэгжүүлээгүй байна. Үүнээс үүдэн 2020-2022 оны хугацаанд газрын төлбөрийн орлоготой холбоотой 52.9 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлэх боломжийг алдсан байна. /хүснэгт №13-аас үзнэ үү/

Хамгаалалтын захиргаа, сумдын Засаг дарга нар газар ашиглаж буй иргэн, аж ахуйн нэгжтэй байгуулсан гуравласан гэрээний биелэлтийг дүгнэх, биелэлтийг хангуулах ажлыг хамтран зохион байгуулаагүй, газар ашиглах эрх олгох, зөвшөөрөлгүй газар ашиглах гэх мэт зөрчлийг таслан зогсоож чадахгүй байгаагаас харахад эрх бүхий байгууллагын хяналт хангалтгүй гэж үзэх боломжтой байна.

ДҮГНЭЛТ:

Аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна.

1. Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуульд заасан эрх хэмжээний хүрээнд УИХ-аас улсын тусгай хамгаалалтад авах шийдвэрийг гарган хилийн заагийн өөрчлөлтийг тухай бүр шинэчлэн баталсан байна.
2. Хамгаалалтын захиргааны байгаль хамгаалагчийн орон тоо хүрэлцээ муутай, боловсрол мэргэжлийн харилцан адилгүй байдал болон техник хэрэгслийн дутмаг байдал нь ажлын үр дүнд сөрөг нөлөө үзүүлэх эрсдэлийг дагуулж байна.
3. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн холбогдох заалтын дагуу тусгай хамгаалалтай газар нутгаас ашигласан нөөцийн төлбөрийн орлогоос хуульд заасан хувь хэмжээгээр тооцож орон нутгийн төсвөөс авах, эх үүсвэрийг нэмэгдүүлэх боломжийг алдсан байна.
4. Газар ашиглах хугацааг сунгуулах хүсэлт гаргаагүй нэгж талбарын газар ашиглах эрхийг цуцлуулах саналыг тухай бүр Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлээгүй, зөвшөөрөлгүй газар ашиглалтын зөрчлийг таслан зогсоох талаар хамгаалалтын захиргаанаас арга хэмжээ авч ажиллаагүй байгаагаас үзэхэд тусгай хамгаалалттай газар нутагт газар олголт, ашиглалтын байдалд тавих хяналт сул, төрийн байгууллага чиг үүргээ бүрэн хэрэгжүүлээгүй нь харагдаж байна.
5. Тусгай хамгаалалттай газар нутагт газар ашиглагч нь байгаль орчны нөлөөллийн ерөнхий болон нарийвчилсан үнэлгээ хийлгээгүй байхад БОАЖЯ-аас газар ашиглуулах эрх олгож байгаа нь байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлэх эрсдэлийг дагуулах үндэслэл болж байна.
6. Тусгай хамгаалалттай газар нутагт газар ашиглаж байгаа иргэн, аж ахуйн нэгжүүдээс Газрын төлбөрийн тухай хуулийн дагуу өсгөн тооцож, орон нутгийн төсөвт газрын төлбөрийг бүрэн төвлөрүүлээгүй зөрчил байгаа нь тухайн нутаг дэвсгэрийг хариуцан ажиллаж байгаа татварын байцаагч, газар ашиглалт хариуцсан мэргэжилтнүүдийн хариуцлагагүй үйл ажиллагаатай холбоотой байна.
7. Хамгаалалтын захиргаа, сумдын Засаг дарга нар газар ашиглаж буй иргэн, аж ахуйн нэгжтэй байгуулсан гуравласан гэрээний биелэлтийг дүгнэх, биелэлтийг хангуулах ажлыг хамтран зохион байгуулаагүй, газар ашиглах эрх олгох, зөвшөөрөлгүй газар ашиглах гэх мэт зөрчлийг таслан зогсоож чадахгүй байгаагаас харахад эрх бүхий байгууллагын хяналт хангалтгүй байна.

ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна.Үүнд:

Хөвсгөлийн улсын тусгай хамгаалалттай газрын Хамгаалалтын захиргааны дарга Г.Энхбаярт:

1. Газар, ой, ус болон байгалийн бусад нөөцийн ашиглалтын талаар менежментийн төлөвлөгөөндөө тодорхой тусгаж, тусгайлсан менежментийн төлөвлөгөө гаргаж, мөрдөж ажиллах.
2. Тусгай хамгаалалттай газар нутагт судалгаа, шинжилгээг идэвхтэй явуулж судалгааны үр дүнд үндэслэн хамгаалалтын горимыг сонгон хэрэгжүүлж, ажлын үр дүнг дээшлүүлж ажиллах.
3. Тусгай хамгаалалттай газар нутагт газар ашиглагч иргэн, аж ахуй нэгжийн мэдээллийг Газрын нэгдсэн мэдээллийн санд бүрэн оруулж, 2022 оны газар ашиглах гэрээг дүгнэхдээ газрын төлбөр төлсөн эсэх байдлыг харгалзан үзэж өмнөх жилүүдийн газрын төлбөрийн үлдэгдлийг төвлөрүүлж ажиллах,
4. Тусгай хамгаалалттай газар нутагт газар ашиглах эрхийн хугацаа дуусвар болсон бөгөөд хугацаа сунгуулах хүсэлт гаргаагүй иргэн, аж ахуйн нэгжийн газар ашиглах эрхийг цуцлах саналыг эрх бүхий байгууллагад хүргүүлэх.
5. Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 31 дүгээр зүйлд тусгайлан заасан байгаль хамгаалагчдын бүрэн эрхийг хэрэгжүүлж ажиллуулах.
6. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос хуульд заасан хувь хэмжээгээр байгаль хамгаалах, нөхөн сэргээх зардлыг хуваарилуулах талаар арга хэмжээ авч ажиллах,
7. Газар ашиглах гуравласан гэрээг дүгнэх ажлыг сумдын Засаг дарга, газар ашиглагч нартай хамтран зохион байгуулж, дүгнэж ажиллах.
8. Хөвсгөл нуурын усан орчныг ашиглаж үйл ажиллагаа явуулж буй иргэн, аж ахуйн нэгжийн моторт завь, усан онгоцонд хяналт тавьж, зөвшөөрөл олгох чиг үүргээ хэрэгжүүлэх.
9. Тусгай хамгаалалттай газар нутагт зөвшөөрөлгүй аялал жуулчлалын үйл ажиллагаа явуулж байгаа зөрчлийг арилгахаар БОАЖЯ-тай хамтран төлөвлөгөө гарган хэрэгжүүлж ажиллах.

Аймгийн татварын хэлтсийн дарга Ч.Хуншагайд:

10. Алаг-Эрдэнэ, Чандмань-Өндөр, Ханх, Рэнчинлхүмбэ сумдын татварын байцаагч нарт тавих хяналтыг сайжруулан ажиллах.
11. Тусгай хамгаалалттай газар нутагт газар ашиглаж байгаа иргэн, аж ахуйн нэгжүүдээс орон нутгийн төсөвт төвлөрүүлээгүй 35.3 сая төгрөгийн газрын төлбөрийг 2023 оны эхний улиралд багтаан барагдуулах.

Алаг-Эрдэнэ, Чандмань-Өндөр, Ханх, Рэнчинлхүмбэ сумдын Засаг дарга нарт:

12. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос тодорхой хувийг тусгай хамгаалалттай газар нутгийн хуулийг хэрэгжүүлэхэд зарцуулахаар хуваарилж, Хөвсгөлийн УТХГ-ын захиргаатай хамтран ажиллах.
13. Газар ашиглах гуравласан гэрээг жил бүр дүгнэж, гуравласан гэрээнд заасан эрх үүргээ хэрэгжүүлж ажиллах.

ЗӨРЧЛИЙН ЖАГСААЛТ:

/Сая төгрөг/

№	Илэрсэн зөрчлийн		Акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Утга	дүн	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн
1	Хөвсгөлийн улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргаа нь менежментийн төлөвлөгөөндөө тусгай хамгаалалттай газар нутгийн зөвшөөрөгдсөн бүсэд ашиглуулах газрын байршил, хэмжээний талаар тусгаагүй байна.	-					1	-
2	Тусгай хамгаалалттай газар нутагт газар ашиглах эрхийн хугацаа дуусвар болсон бөгөөд хугацаа сунгуулах хүсэлт гаргаагүй 34 иргэн, аж ахуйн нэгжийн газар ашиглах эрхийг цуцлах саналд тусган эрх бүхий байгууллагад хүргүүлээгүй байна.	-					1	-
3	Тусгай хамгаалалттай газарт талбар дээр очиж үзэхэд зөвшөөрөлгүйгээр аялал жуулчлалын үйл ажиллагаа явуулах зорилго бүхий жижиг овортой /3х3/ байшин барьсан мөн нэмж байшин барихаар мод, палк буулгасан байдалтай байна. Дээрх зөрчлийг арилгуулах талаар тухайн нутаг дэвсгэрийг хариуцан хяналт тавьж буй албан хаагчийн зүгээс тодорхой арга хэмжээ авсан зүйл үгүй байна.	-					1	-
4	Газар ашиглах гуравласан гэрээг жил бүр дүгнэх ажлыг зохион байгуулаагүй, газар ашиглагчийн төлбөрийн мэдээллийг холбогдох байгууллагад хүргүүлээгүй, газрын төлбөрийг бүрэн ногдуулж төсөвт төвлөрүүлээгүй зэрэг гуравласан гэрээнд заасан эрх үүргээ сумын Засаг дарга нар хэрэгжүүлээгүй байна.	52.9					1	52.9
5	Газрын нэгдсэн мэдээллийн санд 56 иргэн, аж ахуйн нэгжийн мэдээллийг оруулаагүйгээс 2020-2022 онуудад газрын төлбөрийн орлого 94.2 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлэх боломжийг алдсан байна.	94.2					1	94.2
6	Тусгай хамгаалалттай газар нутагт газар ашиглаж буй иргэн, аж ахуй нэгжээс 2020-2022 онд ногдох газрын төлбөрөөс 35.3 сая төгрөгийг төлүүлээгүй байна.	35.3					1	35.3
7	Тусгай хамгаалалттай газар нутгийг хамгаалах ажлыг санхүүжүүлэх хөрөнгийн эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс хуваарилуулж авах талаар арга, хэмжээ авч ажиллаагүй байна.	-					1	-
8	Алаг-Эрдэнэ сумын Засаг дарга нь 2011 – 2018 онуудад 68 нэгж талбарын газрыг аялал жуулчлал, гэр буудал, өвөл, хаваржаа, зуслангийн зориулалтаар захирамж гарган иргэнд газар ашиглуулсан байна.	-			1	-		
9	Аудитын судалгаагаар 68 иргэн тусгай хамгаалалттай газар нутагт зөвшөөрөлгүй	-			1	-		

	аялал жуулчлалын үйл ажиллагаа явуулж байна.							
10	Хамгаалалтын захиргаа нь нуурын усаар хөвөгч /моторт завь, усан онгоц/-д зөвшөөрөл олгож, үйл ажиллагаанд нь хяналт тавих чиг үүргийг бүрэн хэрэгжүүлээгүй байна.	-					1	-
11	Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 3-т заасны дагуу Ойн менежментийн төлөвлөгөө гаргаагүй байна.	-					1	-
	ДҮН	**182.4**	**-**	**-**	**2**	**-**	**9**	**182.4**

ooOoo

Хавсралт №1

Газар ашиглах эрх цуцлахаар хүргүүлсэн саналын жагсаалт

№	Иргэн, ААН, байгууллага	Гэрчилгээ огноо, дугаар	Газрын хэмжээ /га/	Сайдын тушаал	Газар ашигладаг эсэх	Тайлбар
1	Баян бридж ХХК	2015.07.08	3	БОНХАЖ-ын сайдын 2015 оны А-277 тоот тушаал	Газар ашиглаагүй. БОАЖ-ын сайдын 2022/07/08 өдрийн А/267 тоот тушаалаар сунгагдсан.	Газрын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1.6 дугаар зүйл, газрын гэрчилгээ сунгуулах хүсэлт гаргаагүй.
2	Эрдмийн тана ХХК	2020.05.29	0.9	БОАЖ-ын сайдын 2020 оны А/458	Газар ашиглаагүй.	Газрын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1.6 дугаар зүйл, газрын гэрчилгээ сунгуулах хүсэлт гаргаагүй.
3	БОББМ нөхөрлөл	2016.04.18 №2016/0138	2.5	БОНХАЖ-н сайдын 2016 оны А/114 тоот тушаал	Газар ашиглаагүй.	Газрын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1.6 дугаар зүйл, газрын гэрчилгээ сунгуулах хүсэлт гаргаагүй.
4	Наянжинтуул ххк	2014.06.19 №2014-36	2	БОНХ-н сайдын 2014 оны А-220 тоот тушаал	Газар ашиглаагүй.	Газрын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1.6 дугаар зүйл, газрын гэрчилгээ сунгуулах хүсэлт гаргаагүй.
5	ББМ орд ХХК	2007.07.31 №412	2	БО-ны сайдын 2007 оны 116 дугаар тушаал	Үйл ажиллагаа явуулаагүй.	Газрын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1.6 дугаар зүйл, газрын гэрчилгээ сунгуулах хүсэлт гаргаагүй.
6	Хөвсгөл батчандмань ХХК	2014.12.08 № 2014/123	1	БОНХ-н сайдын 2014 оны А-423 тоот тушаал	Хашаа баригдсан. Үйл ажиллагаа явуулдаггүй.	Газрын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1.6 дугаар зүйл, газрын гэрчилгээ сунгуулах хүсэлт гаргаагүй.
7	Сараахай ХХК	2012.08.10	1.2	БОАЖ-н сайдын 2012 оны А-155 тоот тушаал	Газар ашиглаагүй.	Газрын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1.6 дугаар зүйл, газрын гэрчилгээ сунгуулах хүсэлт гаргаагүй.
8	ТНТ жуулчин ХХК	2016.06.30	4.9	БОНХАЖ сайдын 2016 оны А-189 тушаал	2017 онд хашаа барьсан. Газар ашиглаагүй	Газрын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1.6 дугаар зүйл, газрын гэрчилгээ сунгуулах хүсэлт гаргаагүй.
9	Хөвсгөл давалгаа ХХК	2012.06.20	43.7	БОАЖ-н сайдын 2011 оны А-352 тоот тушаал	Газар ашиглаагүй.	Газрын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1.6 дугаар зүйл, газрын гэрчилгээ сунгуулах хүсэлт гаргаагүй.

10	Глобал мост ХХК	2011.08.01	6	БОАЖ-ын сайдын 2011 оны А/232 дугаар тушаал	Газар ашиглаагүй.	Газрын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1.6 дугаар зүйл, газрын гэрчилгээ сунгуулах хүсэлт гаргаагүй.
11	Жанхай тур ХХК	2011.10.12	10	БОАЖ-ын сайдын 2011 оны А/293 дугаар тушаал	Хуучин Жанхай амралтыг хувьчилж авсан. Нийт 4 нэгж талбар ашиглахаар гэрчилгээ авсан.	Газрын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1.6 дугаар зүйл, газрын гэрчилгээ сунгуулах хүсэлт гаргаагүй.
12	Тагнуулын ерөнхий газар	2008.06.23	2	БО-ын сайдын 2008 оны 216 дугаар тушаал	Газар ашиглаагүй.	Газрын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1.6 дугаар зүйл, газрын гэрчилгээ сунгуулах хүсэлт гаргаагүй.
13	Билиг ххк	2011.12.30 №2011-166	2	БОАЖ-ын сайдын 2011 оны А/338 дугаар тушаал	Газар ашиглаагүй.	Газрын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1.6 дугаар зүйл, газрын гэрчилгээ сунгуулах хүсэлт гаргаагүй.
14	***Ирмүүн мальти медиа ххк***	***2012.05.21 № 2012-39***	***4.4***	***БОАЖ-ын сайдын 2011 оны А-491 тоот тушаал***	***Газар ашиглаагүй.***	***БОАЖ-ын сайдын 2022.11.03 өдрийн А/489 тоот тушаалаар хүчингүй болсон***
15	Энгис ХХК	2014.06.13 №2014/33	3.3	БОНХ-н сайдын 2014 оны А-220 тоот тушаал	Газар ашиглаагүй.	Газрын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1.6 дугаар зүйл, газрын гэрчилгээ сунгуулах хүсэлт гаргаагүй.
16	Нордерн монголиа экспедишнс ХХК	2014.06.13	10	БОНХ-н сайдын 2014 оны А-220 тоот тушаал	Газар ашиглаагүй.	Газрын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1.6 дугаар зүйл, газрын гэрчилгээ сунгуулах хүсэлт гаргаагүй.
17	ДЖОСТ ХХК	2015.05.05 № 2015/37	4	БОНХ-н сайдын 2014 оны А-423 тоот тушаал	Газар ашиглаагүй.	Газрын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1.6 дугаар зүйл, газрын гэрчилгээ сунгуулах хүсэлт гаргаагүй.
18	Хүннү медиа ХХК	2015.06.10 № 2015/94	3	БОНХАЖ-н сайд 2015 оны А-222 тоот тушаал	Газар ашиглаагүй.	Газрын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1.6 дугаар зүйл, газрын гэрчилгээ сунгуулах хүсэлт гаргаагүй.
19	Гобитекс ХХК	2015.06.10 № 2015/55	3	БОНХАЖ-н сайд 2015 оны А-222 тоот тушаал	Газар ашиглаагүй.	Газрын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1.6 дугаар зүйл, газрын гэрчилгээ сунгуулах хүсэлт гаргаагүй.

20	Дэвшилт ХХК		3	БОНХАЖ-ын сайд 2015 оны А-222 тоот тушаал	Газар ашиглаагүй.	Газрын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1.6 дугаар зүйл, газрын гэрчилгээ сунгуулах хүсэлт гаргаагүй.
